



Хууль зүй, дотоод  
хэргийн яам



Дэлхийн банкны “Хууль  
зүйн салбарын үйлчилгээг  
сайжруулах” төсөл

# ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ

*Оюутны гарын авлага*

*Зөвлөх:*

Ц.Сарантуяа (ScD), Профессор

*Боловсруулсан:*

Ч.Өнөрбаяр (LL.M)

А.Бямбажаргал (LL.M)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж  
буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд  
боловсруулав.*

Улаанбаатар  
2011 он

DDC  
342.02  
Ө-83

**ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ**  
*ГАРЫН АВЛАГА*

---

**ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:**

Зөвлөх: Ц.Сарантуяа (Sc.D), Профессор

Багийн гишүүд: Ч.Өнөрбаяр (LL.M)

**ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:**

Зөвлөх: Ц.Сарантуяа (Sc.D), Профессор

Багийн гишүүд: Ч.Өнөрбаяр (LL.M)  
А.Бямбажаргал (LL.M)

Эх бэлтгэлд 2011 оны 08-р сарын 24-нд  
Хэвлэлтэнд 2011 оны 09-р сарын 14-нд  
Цаасны хэмжээ: 88,9x119,4/32  
Хэвлэсэн тоо: 500 ширхэг  
Хавтасны дизайныг: Р.Батболд  
Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Цэрэндулам

ISBN: 978-99929-4-926-0



© Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



## ХУУЛЬ ЗҮЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН БАГШ, ОЮУТАН НАРТ



ХЗДХЯ-аас Дэлхийн банкны санхүүжилтээр 2005 оноос эхлэн Эрх зүйн боловсрол олгох их дээд сургуулиудад өргөн цар хүрээтэй сургалтын агуулга, арга зүйн шинэчлэлийн эхлэл тавигдсан билээ. Энэ ажлын хүрээнд 2007 онд «Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт»-ыг боловсруулан батлуулж, түүний дагуу хуулийн сургуулиудын сургалтын жишиг хөтөлбөр, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн юм. Үүний үр дүнд олон улсын жишигт ойртуулсан 33 хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, түүний дагуу оюутанд зориулсан 14 гарын авлагыг

боловсруулсан. Эдгээр хичээлийн хөтөлбөр, гарын авлагыг эрх зүйч бэлтгэдэг улсын болон хувийн хэвшлийн бүх сургуулиудад түгээсэн билээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 156 дугаар тушаалаар баталсан ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги хөтөлбөр /2009-2021/-т «Их, дээд сургуульд эрх зүйч (бакалавр) бэлтгэх сургалтын онол, арга зүйг боловсруулах, гарын авлагаар хангах, стандарт нэвтрүүлэх талаар холбогдох сургуулиудтай хамтран ажиллана» гэж тусгагдсан билээ. Иймд 2009 оноос хэрэгжиж буй Дэлхийн банкны санхүүжилттай Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд заавал болон сонгон үзэх хичээлийн агуулгыг боловсруулах ажлыг үргэлжлүүлж, эдгээр хичээлд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц)-ыг боловсруулан хэвлэх, Клиник сургалтын стандартыг боловсруулж, батлуулах, хуулийн сургуулиудын багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

ХЗДХЯ-ны санаачлагаар дээр дурдсан ажлуудыг Монголын хууль зүйн салбарын нэртэй эрдэмтэд, идэвх санаачлагатай залуу багш нараас бүрдсэн багууд гүйцэтгэж байгаад талархал илэрхийлэхийн ялдамд оюутан, сонсогчдын оюуны хэрэгцээг хангах, сургалтын чухал хэрэглэгдэхүүн болох гарын авлагууд хэвлэгдэн гарч байгаа нь онцгой ач холбогдолтой юм. Энэхүү номыг судлаж буй Та бүхэнд амжилт хүсье.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ДЭД САЙД В.УДВАЛ

## ЦОГЦ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН

### ХӨТӨЛБӨР



Нийгмийн хөгжлийн шинэ шат, эдийн засаг улс төрийн өөрчлөлт, шинэчлэлт бүхэн нь хуульчдын гараар «өлгийдүүлдэг» бололтой. 1206 онд эзэн Чингис хаан Их Монгол улсыг байгуулмагцаа Улсын Их Заргачийг өргөмжилж шинэ тутам улс орны хууль тогтоомжийг сахиулж, сахиагүйд нь өөрийн нэрийн өмнөөс ял цааз асуухыг үүрэг болгосон байдаг. Нээлттэй нийгмийн онолын төлөөлөгч К.Поппер «... шинэ нийгмийн өөрчлөлтийг амжилтад хүргэхийн тулд хуульчдаа бэлтгэх хэрэгтэй»-г зөвлөсөн нь учиртай.

Ийм чухал мэргэжлийг эзэмших оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулахын зэрэгцээ уг мэдлэгээ хуулийн практикт ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших хариуцлагатай үүрэг оногдож байна.

Мэдээлэл, харилцааны технологи хурдацтай хөгжиж буй өнөө цагт зөвхөн багшаар заалгаж мэргэжил эзэмшдэг технологи үеэ өнгөрөөж, өөрөө хийж суралцах технологи сургалтад нэвтэрч байна. Та бүхэнд зориулан боловсруулсан энэхүү гарын авлага ч шинэ тутам энэхүү технологийг аль болох баримтлахыг хичээсэн бөгөөд өөрөө хийж суралцсанаар мэргэжлийн цогц чадамжийг эзэмших боломжтой юм.

*Эрдмийн аяны богц дүүрэн байх болтугай.*

*Хуульзүйн салбарын үйлчилгээг  
сайжруулах төслийн зөвлөх У.Туяа (Ph.D)*



### **Цэрэнбалтавын САРАНТУЯА**

Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), Профессор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Монгол Улсын их сургуулийн профессор ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай,

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон бусад хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдэд гишүүнээр ажилласаи. Монгол Улсад «Төрийн ерөнхий онол»-ын шинжлэх ухааныг сонгодог утгаар нь хөгжүүлэхэд чиглэсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Мөн үндэсний эрх зүйн тогтолцоонд Үндсэн хуулийн процессын эрх зүйн салбар үүсч хөгжиж буй талаарх анхны судалгааны бүтээлүүд туурвиж, энэ салбар эрх зүйн сургалтын хөтөлбөрийг анхлан боловсруулсан. Хуулийн төсөл боловсруулах, хууль хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх, хууль сурталчлах, эрх зүйн дээд боловсрол олгох сургалтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх чиглэлд олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

### **Чадраабалын ӨНӨРБАЯР**


Хууль зүйн ухааны магистр (LL.M)

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрх зүй, торийн онолын тэнхимийн багш

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант. Үндсэн хуулийн эрх зүй,

Харьцуулсан эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийдэг.



### **Алтангэрэлийн БЯМБАЖАРГАЛ**

Хууль зүйн ухааны магистр (LL.M)

МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Твр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш

2007 онд МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2009 онд мөн сургуульдаа Хууль ухааны зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2011 оноос БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторантурт суралцаж байна.

Үндсэн хуулийн процесс, Үндсэн хуулийн эрх зүй, Харьцуулсан эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийдэг.

## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн банкнаас «Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах» чиглэлд хэрэгжүүлж буй төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсрол эзэмшигчдэд зориулан гарын авлага бэлтгэн хэвлүүлж байгаагийн нэг нь «Үндсэн хуулийн процессын эрх зүй»-н энэхүү товхимол юм.

1992 онд Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалах нөхцөл бүрдэж, монголын үндэсний эрх зүйн тогтолцоо Үндсэн хуулийн процесс хэмээх шинэ салбараар хүрээгээ тэлсэн түүхтэй. Эрх зүйн энэ салбар нийтийн эрх зүйн суурь зарчмуудад тулгуурлахын сацуу олон онцлогийг өөртөө агуулдаг. Удалгүй Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн сургалтын төлөвлөгөөнд «Үндсэн хуулийн процесс» хичээл тусгалаа олсноор процессын ухааны цоо шинэ, цогц зохицуулалтын онцлогийг ирээдүйн хуульчдад хүргэх их ажил эхэлсэн.

Үндсэн хуулиас ангид салбар эрх зүй гэж үгүй, хуулийн хэрэгжилт болгон үндсэн хуулийн хүрээнд байх ёстой учир Үндсэн хуулийн процесс нь эрх зүйн аливаа салбарын эхлэл бөгөөд нэгэн зэрэг тулах цэг нь байдаг. Энэ ч утгаараа үндсэн хуулийн процессын эрх зүйг заахад, түүнд суралцахад суурь ухагдахуунуудын талаар нэгдсэн ойлголттой байх, нэгдсэн стандартыг мөрдөх явдал чухал. МУИС-ын Хууль зүйн сургуулийн залуу судлаачид болох Ч.Өнөрбаяр, А.Бямбажаргал нар дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж гарын авлагыг бичихэд оролцсоныг сайшаан тэмдэглэж байна.

Энэхүү гарын авлага үндсэн хуулийг дээдлэх зарчим буюу үндсэн хуульт ёсыг манай оронд төлөвшүүлэхэд ирээдүйн хуульчдын оруулах хувь нэмрийг өндөрсгөхөд дэмжлэг болно хэмээн найдаж байна.

*Үндсэн хуулийн процессын эрхзүйн сургалтын хөтөлбөр болон гарын авлагын зөвлөх Ц.Сарантуяа (Sc.D), профессор*



## ГАРЧИГ

Өмнөх үг

### ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

#### НЭГ. ҮНДСЭН АСУУДАЛ

- |  |       |
|--|-------|
| 1. Үндсэн хуулийн процессын эрх зүйн ойлголт | 8-11  |
| 2. Үндсэн хуулийн хяналтын хэлбэр            | 11-14 |
| 3. Үндсэн хуулийн шүүхийн зориулалт          | 15-20 |

#### ХОЁР. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- |   |       |
|---|-------|
| 4. Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал                | 20-28 |
| 5. Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим                 | 28-31 |
| 6. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, түүний эрх зүйн байдал | 31-38 |
| 7. Цэцийн хэм хэмжээ, харьяалан шийдвэрлэх асуудал      | 38-43 |

#### ГУРАВ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

- |   |       |
|---|-------|
| 8. Цэцэд хандах эрх бүхий субъект   | 44-48 |
| 9. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим                      | 49-54 |
| 9.1. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим                   |       |
| 9.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим                   |       |
| 10. Цэцийн хуралдаанд бэлтгэх, түүний үе шат                              | 54-60 |
| 10.1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх гишүүний ажиллагаа |       |
| 10.2. Цэцийн хуралдаанд бэлтгэх ажиллагаа                                 |       |
| 11. Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, Цэцийн шийдвэр, түүний төрөл    | 60-67 |
| 11.1. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал                    |       |
| 11.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дунд суудал                    |       |
| 11.3. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны их суудал                      |       |
| 12. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч                         | 67-76 |
| 13. Маргааныг цэцийн хуралдаанаар хянан шийдвэрлэх                        | 76-81 |
| 13.1. Хуралдааны үе шат   |       |
| 13.2. Хуралдааны шийдвэр гаргах ба нууц зөвлөлдөх                         |       |
| 14. Маргааныг магадлан шийдвэрлэх   | 81-83 |
| 15. Цэцээс хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох хязгаар                  | 84-85 |

## ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### НЭГ. ҮНДСЭН АСУУДАЛ

**Бүлгийн зорилго:** Үндсэн хуулийн процессын эрх зүй, Үндсэн хуулийн шүүхийн үндсэн зориулалт, хяналтын хэлбэрийн талаар шинжлэх ухааны ойлголттой болно.

#### 1. Үндсэн хуулийн процессын эрх зүйн ойлголт

**Сэдвийн зорилго:** Материаллаг болон процессын эрх зүйн гол ялгаа, Үндсэн хуулийн процессын эрх зүйн суурь ойлголт, түүнийг тайлбарласан онол, үзэл баримтлалтай танилцана.

#### Нэр томъёоны тайлбар:

- *Процессын эрх зүй* Нийгмийн харилцааны тодорхой нэг салбарт үүссэн маргааныг шийдвэрлэх чиг үүрэг бүхий шүүхийн байгууллагаас хууль хэрэглэн шийдвэр гаргах харилцааг зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр
- *Материаллаг эрх зүй* Нийгмийн харилцаанд оролцож буй субъектуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр
- *Үндсэн хуулийн процесс* Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, шийдвэр гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээнээс бүрдсэн салбар эрх зүй
- *Процедурын хэм хэмжээ* Материаллаг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон хэм хэмжээ



#### САЛБАР ЭРХ ЗҮЙН АНГИЛАЛ:


Түүнийг дараах байдлаар ангилж байна:





### МАТЕРИАЛЛАГ ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Материаллаг эрх зүй нь



Нийгмийн харилцаанд оролцож буй субъектуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр.

Жишээ нь:

Үндсэн хуулиар иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан байдаг. Түүнчлэн Үндсэн хуульд иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн байгууллын ундсийг тодорхойлж, иргэдийн оролцоог хэрхэн хангахыг зохицуулсан байдаг.



### ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?


Хууль зүйн бус ердийн хэрэглээнд



«Процесс» хэмээх үгийг



«Явц», «Үйл ажиллагаа» гэж ойлгон хэрэглэнэ.



Хууль зүйн утгаараа: А.

Процессын эрх зүй нь өргөн утгаараа

материаллаг хуулийг хэрэгжүүлэх журам буюу **процедурыг** тогтоосон хэм хэмжээнээ» бүрдэнэ.

Жишээ нь

Үндсэн хуулийг материаллаг хууль гэж үзэхэд түүний хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан УИХ-ын тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, Засгийн газрын тухай, Ерөнхийлөгчийн тухай болон тэдгээртэй адилтгаж болохуйц бусад хуульд агуулагдаж буй хэм хэмжээ нь процедур буюу журам тогтоосон байдаг.

# ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

Б.

Процессын эрх зүй нь **иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, таслан явцуу утгаараа шийдвэрлэх эсхүл магадлан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээнээс бүрдэнэ.**

Жишээ нь

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байгаа эрх зүйн харилцаа.



ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕСС ГЭДЭГТ ЮУГ ОЙЛГОХ ВЭ?

Процессын эрх зүй нь машериллаг хуулийг зөрчсөн тохиолдолд үүсдэг маргааныг шүүхээс шийдвэрлэх үед тухайн хуулийг хэрэглэн нэг бүрчилсэн шинжтэй заавал биелэгдэх шийдвэр гаргах үйл явцыг зохицуулна.

Үндсэн хуулийн процессын эрх зүйн нь Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүй хэм хэмжээнээс бүрдсэн салбар юм.




МАТЕРИАЛЛАГ БА ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХАМААРАЛ

Материаллаг хэм хэмжээ

Процессын хэм хэмжээ

Материаллаг ба процессын хэм хэмжээнүүд нь **өөр хоорондоо шууд хамааралтайгаар** нийгмийн харилцааг зохицуулж байдаг.

Үүнийг дүрсэлбэл:





### **Хяналтын асуулт:**

1. Материаллаг ба процессын эрх зүйн харилцан хамаарлыг тайлбарла.
2. Процессын ба процедурын хэм хэмжээний гол ялгааг тайлбарла.
3. Үндсэн хуулийн процесс болон захиргааны процессын ялгааг тайлбарла.
4. Үндсэн хуулийн процесс гэдэгт юуг ойлгох вэ?

### **Сорил:**

1. **Үндсэн хуулийн цэц нь маргааныг хянан шийдвэрлэхдээ аль төрлийн хуулийг хэрэглэх вэ?**
  - a) Материаллаг хууль
  - b) Процессын хууль
  - c) Гагцхүү материаллаг хуулийг
  - d) Гагцхүү процессын хуулийг
2. **Монгол Улсын Үндсэн хууль нь:**
  - a) Материаллаг хууль
  - b) Процессын хууль
  - c) Аль алины нь шинжийг агуулсан
  - d) Бодлогын баримт бичиг
3. **Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль нь:**
  - a) Материаллаг хууль
  - b) Процессын хууль
  - c) Органик хууль
  - d) Кодекс

### **Эх сурвалж:**

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005.
2. Конституционное (государственное) право зарубежных стран, Общая часть. М., 1996, Стр. 9
3. Н.В. Витрук, Конституционное правосудие. Судебное конституционное право и процесс, М., 1998.
4. Эрх зүй. Сэтгүүл. № 4-5, 2001, 16-17 дах тал.
5. С.Нарангзрэл. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. УБ., 2009. 117 дахь тал.

### **2. Үндсэн хуулийн хяналтын хэлбэр**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн хяналтын хэлбэр тэдгээрийн үндэслэл болж буй үндсэн хуульд ёсны онол, арга зүйг эзэмшинэ.

## Нэр томъёоны тайлбар:

- *Хийсвэр хяналт* Амьдралын тодорхой нэг зөрчил буюу маргаанаас ангид байдлаар эрх бүхий субъектуудын хүсэлтээр хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр
- *Тодорхой хяналт* Ердийн болон дагнасан шүүхээс өөрийн харьяаллын хэрэг, маргааныг шийдвэрлэх явцад хэрэглэж буй хуулиа үндсэн хууль зөрчиж байна гэж үзвэл ҮХШ-д хандах хэм хэмжээний хяналтын хэлбэр
- *Урьдчилсан хяналт* Эрх зүйн актыг хүчин төгөлдөр болохоос нь өмнө хянах хэм хэмжээний хяналтын хэлбэр
- *Негатив хяналт* Тодорхой асуудлаар хууль гаргахаар үндсэн хуульд заасан атал хууль тогтоогчоос тэрхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэрэгждэг хэм хэмжээний хяналтын хэлбэр

## 2.1. Хэм хэмжээний хяналт<sup>1</sup>



### УРДЧИЛСАН ХЯНАЛТ ЯМАР ДАВУУ ТАЛТАЙ ВЭ?

Хяналтын энэ хэлбэрийг олон улсын гэрээний хувьд хэрэгжүүлэх нь нэлээл давуу талтай байдаг. Учир нь гэрээг нэгэнт хүчин төгөлдөр болсон хойно нь Үндсэн хуульд нийцээгүй хэмээн үзэж хүчингүй болгох нь **олон улсын гэрээг заавал биелүүлэх ёстой** (pacta sunt servanda) гэсэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчимтай зөрчилддөг. Нөгөө талаас хүчин төгөлдөр болсон гэрээг Үндсэн хууль зөрчиж байна гэж шийдвэрлэсэн ч энэ нь нэг улсаас нөгөө улсын өмнө **олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хориглох үндэслэл болдоггүй**.


<sup>1</sup> Нийтээр дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг шийдвэрлэдгээрээ онцлогтой. Энэ нь Үндсэн хууль бол хамгийн дээд хүчин чадалтай баримт бичиг гэсэн үзэл онолд тулгуурладаг.



**ХИЙСВЭР ХЯНАЛТЫН ОНЦЛОГ:** Хийсвэр хяналтыг ашиглан формал хуулиудыг үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянадаг. Зарим тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрүүд болон орон нутгийн шинж чанартай эрх зүйн актуудыг мөн хянадаг онцлогтой. Харин ийм төрлийн маргааныг шийдвэрлүүлэхээр иргэн хүн үндсэн хуулийн шүүхэд ханддаггүй.

## 2.2. Хяналтын бусад хэлбэр

Зарим улсад үндсэн хуулийн шүүх нь хэм хэмжээний бус хяналтыг хэрэгжүүлдэг. Тодруулбал, үндсэн хуулийн байгууллагууд хоорондын маргаан, улс төрийн намыг тараах эсэх, сонгууль болон ард нийтийн санал асуулгын талаар үүссэн маргаан, зарим улсад ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах асуудлыг шийдвэрлэдэг. Тухайлбал, Австрийн үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн 142 ба 143 дугаар зүйлийг үндэслэн Төрийн холбоо болон гишүүн улсын өндөр албан тушаалтнуудын үндсэн хууль зөрчсөн болон албан тушаалаас нь огцруулах, эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээлгэхүйц үйлдлийг авч хэлэлцэх, шийдвэр гаргах эрхтэй байдаг.



### Хяналтын асуулт:

1. Урдчилсан хяналтын давуу болон сөрөг талыг тайлбарла.
2. Иргэд өөрийн үндсэн эрх зөрчигдсөн гэх үндэслэлээр Цэцэд хандаж болох уу? Яагаад, тайлбарла.
3. Негатив хяналтыг Монгол улсад хэрэгжүүлж болох уу?
4. Засгийн газар, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хооронд үүссэн маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх үү?

### Сорил:

**1. Иргэн «А» УИХ-ын сонгуульд нэр дэвшжээ. Санал хураалтаар тэрээр маш бага саналын зөрүүтэйгээр ялагдсан. Сонгуулийн дараагаар «А» УИХ-ын сонгуулийн тухай хуулийн санал тоолохтой холбоотой хэд хэдэн заалт Үндсэн хууль зөрчиж буй болохыг анзаарч Үндсэн хуулийн цэцэд ханджээ. Энэ тохиолдолд «А»-ийн Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан гомдол ямар хэлбэртэй байх вэ?**

- a) А өргөдөл гаргасан
- b) А мэдээлэл гаргасан

- c) А хүсэлт гаргасан
- d) А нэхэмжлэл гаргасан

**2. Хэм хэмжээний хийсвэр хяналтад аль нь хамаарахгүй вэ?**

- a) Дээд шүүхийн хүсэлтээр маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн маргаан
- b) Иргэний мэдээллээр маргаан үүсгэн хянан шийдвэрлэсэн маргаан
- c) Хуулийн этгээдийн өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэсэн маргаан
- d) Шүүгч маргаан хянан шийдвэрлэх явцад хэрэглэж буй хуулиа Үндсэн хууль зөрчсөн хэмээн ҮХЦ-д хандан гаргасан хүсэлт

**3. Нийслэлийн захиргааны хэргийг шүүхийн шүүгч «Б» газартай холбоотой маргаан хянан шийдвэрлэж байжээ. Тэрээр нэхэмжлэлийг шалгаж байх зуур уг маргаантай холбоотойгоор хэрэглэх гэж байсан Газрын тухай хуулийн тодорхой заалт Үндсэн хууль зөрчиж байгаа гэж үзсэн тул Улсын дээд шүүхэд уламжилсан бөгөөд Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд ханджээ. Цэцээс уг хүсэлттэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэж буй хяналт нь аль хяналтын хэлбэрт илүүтэйгээр хамаарах боломжтой вэ?**

- a) Абстракт буюу хийсвэр хяналт
- b) Хэм хэмжээний тодорхой хяналт
- c) Хэм хэмжээний негатив хяналт
- d) Хэм хэмжээний урьдчилсан хяналт

**Эх сурвалж:**

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
2. Конституционное (государственное) право зарубежных стран, Общая часть, М., 1996
3. Н.В. Витрук, Конституционное правосудие. Судебное конституционное право и процесс, М., 1998
4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхтгэл). УБ., 2007
5. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. УБ., 2009. 117 дахь тал



### 3. Үндсэн хуулийн шүүхийн зориулалт

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн шүүхийн онцлог, үндсэн зориулалтыг орчин үеийн үндсэн хуульт ёсны үзэл баримтлалаар судалж, энэ талаар цэгцтэй мэдлэгтэй болно.

#### *Нэр томъёоны тайлбар:*


- **Үндсэн хууль** Үндсэн хууль нь хүний үндсэн эрхийг хамгаалах зорилгоор төрийн байгууллагын үндсийг тодорхойлсон, хууль зүйн дээд хүчин чадалтай, хэм хэмжээний нийлбэр
- **Үндсэн эрх** Үндсэн эрх нь эн тэргүүнд төрөөс эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг эрх зүйн хамгаалалт болж байдаг.
- **Шууд үйлчилдэг эрх зүй**  
Үндсэн хуульд ёсны онолоор хүний жам ёсны эрх нь эрх зүйн үндсэн хэм хэмжээ хийгээд зарчмуудад зайлшгүй тусгалаа олсон байх ёстой. Ийнхүү үндсэн хуульд тусгалаа олж буй хэсэг нь үндсэн эрх юм. Үндсэн хууль бусад хуулийн нэгэн адил нийгмийн харилцааг зохицуулах чиг үүргээ бодитойгоор хэрэгжүүлэх үйл явц. Ингэхдээ Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн талаарх заалтууд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн шийдвэрийг хязгаарлах хүчин чадалтай байж дээрх гурван эрх мэдлийн шийдвэр үндсэн эрхийг зөрчихгүй байна, хэрэв зөрчвөл үндсэн хуулийн шүүхээс түүнийг нь сэргээх боломжтой байх ёстой.
- **Үндсэн хуулийн тайлбар**  
Үндсэн хууль зөрчигдсөн эсэхийг Үндсэн хуулийн зүйл, заалт, утга агуулгад нийцүүлэн шийдвэрлэх ажиллагаа.
- **Үндсэн хуулийг дээдлэх зарчим**  
Үндсэн хуулийг төрийн гурван эрх мэдлээс, түүний дотор хууль тогтоогчоос дээгүүрт тооцон хүлээн зөвшөөрөх үзэл баримтлал.
- **Аутентик тайлбар**  
Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах албан ёсны тайлбарын нэг. Эрх зүйн хэм хэмжээг батлан гаргасан байгууллагаас хийж буй тайлбар.
- **Казуаль тайлбар**  
Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах албан ёсны тайлбарын нэг. Тодорхой тохиолдолд хуулийг хэрэглэж буй субъектээс хийж буй тайлбар. Хуулийг хэрэглэх нь түүнийг биел үүлэх, хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөөс зарчмын ялгаатай тул гагцхүү шүүх л хуулийг хэрэглэдэг. Иймд Үндсэн хуулийн шүүх нь хэрэг маргаан шийдвэрлэх замаар Үндсэн хуульд энэ төрлийн тайлбарыг хийж байдаг.
- **Абстракт тайлбар**  
Эрх зүйн зүйн хэм хэмжээг тайлбарлах аргын нэг. Хуулийг тодорхой хэрэг маргаан шийдвэрлэх явдлаас ангид буюу хийсвэр байдлаар тайлбарлахыг ойлгоно.



**Үндсэн хууль нь:** Төр ба шударга ёсны талаарх ард түмний төсөөлөл, үнэлэмжийг бэхжүүлэн төрөөс иргэдтэй харилцах харилцааны суурийг тодорхойлсон, тусгай журмаар батлагдаж, хүндрүүлсэн журмаар өөрчлөгдөх дээд хэм хэмжээний нийлбэр мөн.



*Үндсэн хуулийг дараах байдлаар ангилна:*



*Үндсэн хуулийн шүүх бий болох шалтгаан:*

Үндсэн хуулийн биелэлтийг хангах байгууллага - шүүх үүссэн явдал нь **Үндсэн хууль оршин байгаатай, түүний биелэлтийг хангах мөн хууль зүйн үүднээс хамгаалах зорилготой.** Нөгөөтэйгүүр үндсэн хуулийн шүүхгүйгээр Үндсэн хууль тунхаг төдий зүйл болох аюултай учир түүний **бодитойгоор оршин байх гол баталгаа** нь Үндсэн хуулийн шүүх юм.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ЗОРИУЛАЛТ

Үндсэн хуулийн шүүх олон зориулалттай байдаг хэмээн тайлбарладаг боловч түүний мөн чанарыг тод илэрхийлдэг дараах хоёр зориулалт байдагтай судлаачид санал нэгддэг.

### Нэгдүгээр зориулалт нь:

**Нэгдүгээрт:** Үндсэн хуулийг «**шууд үйлчилдэг**» эрх зүй болгох

Үндсэн хуулийн шүүхийн зориулалт

**Хоёрдугаарт:** Үндсэн хуулийг «**тайлбарлах**»

Үндсэн хуулийг «**шууд үйлчилдэг**» эрх зүй болгох

Үндсэн хуулиар тунхагласан **хүний үндсэн эрхүүд** нь тунхаг төдий бус бодит амьдралд хэрэгждэг байх ёстой. Өөрөөр хэлбэл, үндсэн эрх нь зөрчигдсөн хүн бүрт уг эрхээ шүүхийн журмаар сэргээлгэх боломж нээлттэй байх ёстой. Үндсэн хуулийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох үндсэн эрхийг шууд үйлчилдэг болгох замаар төрийн дур зоргыг хязгаарлах боломж бий болно.

### Хоёрдугаар зориулалт нь:

Үндсэн хууль, түүний дотор хүний үндсэн эрх шууд үйлчлэх явдал, төрийн бүхий л эрх мэдлийн байгууллага Үндсэн хуульд захирагдах явдал нь Үндсэн хууль дээдлэх зарчмын илрэл юм.

*Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн хувьд энэ зориулалтаа хэрэгжүүлж буй эсэх?*

Гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны зүгээс үндсэн эрхийг зөрчсөн тохиолдолд үндэсний эрх зүйд заасан хууль зүйн бүх шат дамжлагыг дүүргэсний дараагаар үндсэн эрхийн зөрчил байгаа эсэхийг тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд хандан өргөдөл гаргах боломж бүрдээгүй.

<p>Үндсэн Хуулийг «тайлбарлах»</p>	<p>Үндсэн хуулийн шүүх амьдралын тодорхой нэг тохиолдлыг шийдвэрлэх замаар эрх зүйн ерөнхий онолд заасан аргуудыг ашиглан Үндсэн хуулийг тайлбарладаг. Үндсэн хуулийн хэм хэмжээг хөгжин өөрчлөгдөж буй түүхэн болон тухайн нөхцөл байдалд хамааруулан тодорхой болгох шаардлага урган гардаг. Ийм нөхцөл байдалд Үндсэн хуулийн шүүхийн хяналтын цар хурээ нь Үндсэн хуулийг тайлбарлах аргаас шийдвэрлэх байдлаар хамаарна. Шүүх өөрийн хэрэглэж буй Үндсэн хуульдаа явцуу болон дэлгэрэнгүй байдлаар, «улс төрийн» эсхүл дан ганц «эрх зүйн» тайлбарыг хийнэ.</p>
--	--

*Үндсэн хуулийг хэн тайлбарлах вэ?  
Эрх зүйг хэрхэн тайлбарлах вэ?*

Хэн тайлбар хийх боломжгүй вэ?

Хуулийг тэр тусмаа Үндсэн хуулийг ямар ч тохиолдолд хуулийн бус байгууллага **тайлбарлах боломжгүй** юм. Үүний тод жишээ нь Парламент юм. (Парламент хууль тогтоох үйлжиллагаагаараа дамжуулан үндсэн хуулийг тайлбарладаг гэсэн үзэл баримтлал байдаг)

Хэн тайлбар хийх вэ?

Үндсэн хууль болон аливаа бусад хуулийг хэрэглэх эрх бүхий байгууллага (шүүх) нь **хэрэглэж буй** эрх зүйн хэм хэмжээгээ маргаантай тодорхой тохиолдолд тулгуурлан гаргаж буй шийдвэрийнхээ үндэслэл хэсэгт тусгах замаар (казуаль) тайлбарладаг нь эрхзүйн онолын хувьд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.

Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нь

Гагцхүү хуулийг хэрэглэх явцад л хэрэгжих боломжтой. Энэ нь хууль хэрэглэж буй (шүүх) байгууллага шийдвэрийнхээ холбогдох хэсэгт тухайн шипдэлд хүрэх болсон үндэслэлийг эрх зүйн онолд заасан, тайлбар хийх боломжийн бүхий л аргыг ашиглан талуудад ойлгомжтой байдлаар тайлбарлаж буй үйл ажиллагаа.



*Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хувьд энэ зориулалтаа хэрэгжүүлж буй эсэх?*

Эрх зүйн социалист бүлд хамаарч байсан улсуудад хуулийн албан ёсны тайлбарыг бие даасан «тусгайлсан» баримт бичгээр л хийгдэх ёстой хэмээн үзэж ирсэн. Шүүхийн шийдвэр өөрөө хуулийн тайлбар мөн гэсэн ойлголт эдүгээ улам бүр төлөвшиж байна.

**Хяналтын асуулт:**

1. Үндсэн хууль түүний ангилалтын талаар ярилц.
2. Чухам яагаад Үндсэн хууль шууд үйлчилдэг эрх зүй болох шаардлагатай вэ?
3. Үндсэн хуулийг хэн тайлбарлах талаар ярилц.
4. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр тайлбар мөн үү.

**Сорил:**

Иргэн «А» Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд «Л» намаас нэр дэвшихээр болжээ. Ерөнхийлөгчийн сонгууль болохоос өмнө Монгол Улсын Их Хурлаас нэгэн тогтоол гаргажээ. Энэ нь «Монгол улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 4 дахь хэсгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай» 27 дугаар тогтоол аж. Тус тогтоолоор Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх харилцааг зохицуулсан Үндсэн хуулийн заалтыг тайлбарласан.

Уг тогтоол нь:

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**Дугаар 27**

**2008 оны 10 дугаар сарын 20-ны өдөр**

**Улаанбаатар хот**

*Монгол улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэххэсгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай*

**Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ НЬ:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэн хүлээн зөвшөөрөх тухай хууль гаргах үндэслэлийг зохицуулсан Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалтыг дараах байдлаар ойлгон хэрэглэж байхаар тогтоосугай: «... нийт сонгогчийн олонхийн санал авсан ...» гэдгийг Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгсөн сонгогчдийн ердийн олонх буюу санал хураалтын дүнгийн хувьд олонх болсон гэж ойлгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА .....

Ерөхийлөгчийн сонгууль болж дүнг гаргахад нэр дэвшигч «Б» нь «А»-аас илүү санал авчээ. Сонгууль эрхлэн явуулсан байгууллагаас саналыг тоолж дүнг гаргахдаа УИХ-ын уг тогтоолыг үндэслэл болгосон.

### Асуулт:

1. УИХ-ын тогтоол Үндсэн хуульд нийцсэн үү?
2. Үндсэн хуулийг тайлбарлах субъект хэн бэ?

### Эх сурвалж:

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005. 44- 57 дах тал.
2. Конституция Российской Федерации научно- практический комментарий, М., 1997. С 153.
3. Монголын төр эрх зүй. Сэтгүүл., УБ. 2001. №2, 1-10 дах тал.
4. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар. УБ. 1999. 50 дахь тал.
5. Rechtswörterbuch, 13. Auflage, Muenchen, 1996, S. 132.
6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ. 2007. 143- 157дахь тал.
7. М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёс. УБ. 2010.

## ХОЁР. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

**Бүлгийн зорилго:** Үндсэн хуулийн цэц үндсэн хуулийн байгууллага байгууллага болохыг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс судалж, энэ талаар зөв ойлголттой болно.

### 4. Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн хяналт түүний ангилал, хяналтын загварыг судалж, улмаар үндсэн хуулийн цэцийн онцлогтой танилцана.

### Нэр томъёоны тайлбар:

- **Дээд хяналт** Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх гол арга хэлбэр. Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь Үндсэн хуулийг хэрэгжүүлэх гол баталгаа болохынхоо хувьд хараат бус байх (маргаан хянан шийдвэрлэх болон үйл ажиллагааны хувьд), өөрийн дэгтэй байх шаардлагатай. Улмаар үндсэн хуультай холбогдох аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх байдлаар уг хяналтыг хэрэгжүүлнэ. Чухамдаа энэ монополь байр суурь нь Үндсэн хуулийн хувьд дээд хяналт болдог.



- **Үндсэн хуулийн байгууллага**


Үндсэн хуулиар эрх хэмжээ нь тодорхойлогдохоос гадна төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шууд оролцох институт л үндсэн хуулийн байгууллага болно. Нөгөөтэйгүүр Үндсэн хуульд заасан байгууллага болгон үндсэн хуулийн байгууллага гэх статусыг эдлэхгүй.

Үндсэн хуулийн хяналт ба түүний ангилал, загвар



**ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН АНГИЛАЛ БА ЗАГВАР**

Үндсэн хуулийг тунхаглал төдий бус, харин төрийн хамгийн дээд хүч нь эрх зүйн акт буюу жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх боломжийг бий болг дэлхий дахинд түүнд хяналт тавих хэд хэдэн арга механизмыг бий болсон.





## ҮНДСЭН ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ШҮҮХИЙН БАЙГУУЛЛАГААС ХЯНАХ НЬ

Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих **АМЕРИК** загвар

*Үүссэн шалтгаан:*

*Онцлог:*

1803 онд АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Дж.Маршалл, Дж.Мэдисоны эсрэг У.Мэрбэригийн хэргийг шийдвэрлэхдээ «Холбооны улсын Үндсэн хууль бол төрийн дээд хууль учир түүнийг зөрчиж гарсан Конгрессийн аливаа хуулийг шүүх Үндсэн хууль зөрчсөн хэмээн тооцох боломжтой» хэмээн шийдвэрлэсэн. Ингэхдээ АНУ-ын дээд шүүхэд энэ төрлийн маргаан хянан шийдвэрлэх эрхийг хэн ч олгоогүй байсан бөгөөд эл эрхийг **өөртөө олгож** шийдвэрлэсэн.

Үндсэн хуулийн хяналтыг эрүүгийн болон **иргэний** хэргийг хянан шийдвэрлэх явцад **ердийн шүүхээс хэрэглэх гэж буй хууль Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тухайн шүүх өөрөө** хянан шийдвэрлэдэг.

**Энэ загвар нь дотроо дараах байдлаар хуваагдана:**



Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих **ЕВРОП** загвар

*Үүссэн шалтгаан*


*Онцлог:*

Хяналтын энэхүү загварыг анх Австрийн хуульч, эрдэмтэн Ханс Кельзен бий болгосон. Энэ загвар 1920 оны Австрийн Холбооны улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад бүрэлдэж, Үүссэн «ухамсартай»-гаар бий болсон. Ингэхдээ ердийн шалтгаан: шүүхүүд өөрт нь эрх олгоогүй байхад Үндсэн хуульд нийцээгүй гэсэн шалтгаанаар хуулийг хүчингүй болгох бус **хуулиар эрх олгосон тохиолдолд бие даасан өөр шүүх хэрэгжүүлэх байдлаар бий болсон.** Үндсэн хуулийн биелэлтийг ердийн шүүх бус харин үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх зориулалт бүхий **бие даасан өөр шүүх** хэрэгжүүлдэг.



*Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэрээр үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх журам:*

### ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО




*ҮНДСЭН ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ШҮҮХИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ХЯНАХ НЬ*

Үндсэн хуулийн биелэлтийг  
**ҮНДСЭН ХУУЛИЙН ЗӨВЛӨЛӨӨС**  
хянах нь

*Үүссэн шалтгаан:*

*Онцлог:*

Үндсэн хуулийн биелэлтийг шүүхийн бус шинжтэй байгууллага хянах эхлэл нь Францын үндсэн хуулийн «**жюри**» буюу «**зөвлөл**»-өөс үүдэлтэй. Ингэхдээ тус зөвлөл нь хуулиудыг **Үндсэн хуульд нийцэж** байгаа эсэхийг ажиглах үүрэгтэй байжээ. Үндсэн хуулийн шүүхээс ялгагддаг гол онцлог нь «**урдчилсан хяналтыг**» хэрэгжүүлдэгт оршдог. Ингэхдээ органик хууль болон парламентын танхимын дэгийн тухай хуулиудыг төсөл байхад нь хянадаг.



Үндсэн хуулийн цэц үндсэн хуулийн шүүх болох нь



## ШҮҮХ БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГ

Шүүх нь эрүү, иргэн, захиргааны чиглэлээрхэрэг, маргааныг процессын хуульд заасан журам ёсоор шүүн таслах ажиллагааг явуулах эрх бүхий байгууллага

Шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж маргаанд зөв шийдэл гаргах эрх, үүрэг бүхий байгууллага.

*Дараах шалгуураар шүүх мөн эсэхийг тогтооно:*

Шалгуур		Тайлбар
Нэгдүгээрт	Өөрийн санаачилгаар маргаан үүсгэдэггүй байх	Шүүх нь <b>өөрийн санаачилгаар</b> бус харин эрх бүхий субъектээс түүнд хандсанаар (нэхэмжлэл, хүсэлт, гомдол, өргөдөл болон бусад үндэслэлээр) хэрэг маргааныг үүсгэдэг. Энэ нь шүүх төвийг сахисан байр сууринаас асуудлыг шийдвэрлэдэг болохыг тодотгож өгдөг.
Хоёрдугаарт	Материаллаг хууль хэрэглэдэг байх	Шүүх болгон хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ аль нэг <b>материаллаг хуулийг хэрэглэдэг</b> . Хуулийн зүйл, заалтуудад тулгуурлан хэрэг, маргааныг шийдвэрлэн түүний үр дүнд заавал биелэгдэх захирамжилсан шийдвэр гаргадаг. Шүүхийн шийдвэр <b>хуулийг хэрэглэх үндсэн дээр гардаг</b> , тухайн харилцаанд оролцогчдын хувьд хуулийг тайлбарлан өгч буй <b>казуаль тайлбар</b> мөн.
Гуравдугаарт	Маргааныг эцэслэн шийдвэрлэдэг байх	Шүүхийн бусад байгууллагаас ялгагдах нэг шалгуур бол тэрээр маргааныг дээд шатандаа <b>эцэслэн шийдвэрлэдэгт</b> оршдог. Энэ нь тухайн маргааныг шүүх эрх мэдлээс л эцэслэн шийдвэрлэх түүний <b>онцгой үнэт чанар</b> юм.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ШҮҮХ БОЛОХ НЬ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛЬД

*Жаран дөрөвдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт: «Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн» хэмээн зохицуулсан билээ.*



**Цэц шүүх мөн үү? Цэцийг шүүхэд тавигдах шалгуураар авн үзвэл**

Шалгуур		Монгол улсын Үндсэн хууль
Нэгдүгээрт	Өөрийн санаачилгаар маргаан үүсгэдэггүй байх	Жаранзургаа дугаар зүйлийн 1 дэх хэсэгт « <i>Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг <b>иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчү Ерөнхий сайд Улсын дээд шүүх Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ</b></i> » гэж зохицуулсан. Үүнээс үүдэн Цэцэд хандахаар хуульд заасан эрх бүхий <b>субъектын өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг л үндэслэж</b> маргаан хянан шийдвэрлэдэг. Үндсэн хуульд өөрийн санаачилгаар гэж заасан нь Цэцэд олгож буй онцгой эрх юм. Өөрөөр хэлбэл, Цэц иргэдийн өргөдөл, мэдээллийг хүлээн аваад маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэдэг. Өргөдөл, мэдээлэл ирүүлээгүй байхад өөрийн санаачилгаар маргаан үүсгэхгүй.
Хоёрдугаарт	Материаллаг хууль хэрэглэдэг байх	Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт « <i>Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд <b>дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн</b></i> » хэмээн зохицуулсан билээ. Ийнхүү үндсэн хуулийн биелэлтийг хамгаалж байдгаараа Цэц шийдвэр гаргахдаа Үндсэн хуулийг хэрэглэдэг, өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг маргаан шийдвэрлэх <b>хэмжүүр</b> болгодог байна. Мөн Цэц шийдвэрээ Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргадаг бөгөөд маргааныг хянан шийдвэрлэж <b>дүгнэлт, магадлан шийдвэрлэж тогтоол</b> гаргадаг ба энэ нь хуулийг хэрэглэх замаар шийдвэр гаргаж буй үйл ажиллагаа юм.
Гуравдугаарт	Маргааныг эцэслэн шийдвэрлэдэг байх	Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «... <i>Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд <b>дээд хяналт тавих, . . . маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллагаж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа шийдвэрлэдэг мөн</b></i> » хэмээн зохицуулсны дагуу Цэц хууль зүйн дээд байх хүчин чадалтай шийдвэр гаргадаг, түүний шийдвэрийг дахин хянах буюу өөрчлөх эрх бүхий шат дамжлага байдаггүйг нотолж байна.

Дээрх шалгуураар авч үзвэл **ЦЭЦ** нь

Шүүх байгууллагад тавигдах шалгуурыг **Үндсэн хуульд заасны дагуу хангаж байна**. Харин «Цэц» хэмээх оноосон нэр хэрэглэсэн нь Монгол Улсад **Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх шүүхийн онцлог** бөгөөд түүхэн уламжлалтай холбоотой.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Цэц үндсэн хуулийн байгууллага болохын тулд дараах шалгуурыг хангах ёстой

Маргаан хянан шийдвэрлэх болон үйл ажиллагааны хувьд **хараат бус байх**

Үйл ажиллагааны **дэгтэй байх**

*Үндсэн хуулийн цэцийн хувьд дээрхи шалгуурийг дараах байдлаар хангаж байна:*

- Үндсэн хуулийн цэцийн хувьд **маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа хараат бус байх** явдал хуулиар баталгаажсан байдаг бол захиргааны үйл ажиллагааны хувьд **цэц ажлын албатай түүний орон тоог Цэцийн дарга** тогтоодог. Мөн төсвийг хуульд заасны дагуу бие даан захиран зарцуулдаг.

**Цэц хараат бус**

- Шүүхийн захиргааны болон хуралдааны үйл ажиллагааг хуулиар нарийвчлан зохицуулах боломжгүй тул Цэц дэгээ өөрөө тогтоох боломжтой байдаг.
- Эдүгээ цэцийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн тухай цэцийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байна.

**Цэц үйл ажиллагааны дэгтэй**

Үндсэн хуулийн цэцийн ердийн шүүхээс ялгагдах нэг онцлог нь **үндсэн хуулийн байгууллага гэдэгт** оршдог. Өөрөөр хэлбэл, цэц үндсэн хуулийн шинжтэй байгууллага болоод шүүх юм.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ҮНДСЭН ХУУЛЬД ДЭЭД ХЯНАЛТ ТАВЬДАГ

Цэцээс Үндсэн хуульд дээд хяналт тавьдаг гол шинэс нь:

Нэг.	Хоёр.	Гурав.
Биелэлтийг хянах зүйл нь зөвхөн Үндсэн хууль бөгөөд тэрээр хууль тогтоомжийн хамгийн дээд хүчин чадалтай акт юм.	Үндсэн хуулийн биелэлтийг төр, засгийн хамгийн дээд байгууллага, албан тушаалтан хэрхэн хэрэгжүүлж байгааг хянадаг.	Үндсэн хуулийн цэц хууль зүйн дээд хүчинтэй шийдвэр гаргадаг.

Үндсэн хуулийн цэц дээд хяналтыг хэрэгжүүлэх нь:

### Нэг

Үндсэн хууль бол маргааныг хянан шийдвэрлэх **хэмжүүр** юм. Хяналтын бүх объектыг гагцхүү үндсэн хууль, түүний утга, санаа, үг, үсэгт нийцүүлэн шалгана.

### Хоёр

Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийнхаа **шууд үйлчлэлийг хангах зориулалтаар** ажиллах ба улмаар үндсэн хууль өөрөө дээд **хүчин чадалтай байж** түүнийг **бүх субъект** заавал биелүүлэх ёстой. Ялангуяа, төрийн байгууллага, албан тушаалтанд энэ нь шууд хамаарна. Гэвч Цэцийн хянан шийдвэрлэх маргаан эдүгээ хэт явцуу хүрээнд хэрэгждэг.

### Гурав

Үндсэн хуулийн цэц нь маргааныг шийдвэрлэж магадлал, дүгнэлт, тогтоол гаргана. Маргааныг цэц **эцэслэн шийдвэрлэж** тогтоол гаргадаг. Түүнийг цаашид хэн ч **авч хянах эрхгүй**.

**Хяналтын асуулт:**

1. Шүүх эрх мэдэл, түүнд тавигдах шалгуурыг ашиглан хэлэлцүүлэг явуулах.
2. Үндсэн хуулийн хяналтын загварууд, тэдгээрийн онцлогын талаар ярилц.
3. Үндсэн хуулийн хэрэгжилтэд тавих дээд хяналт хэрхэн хэрэгжих вэ?
4. Хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэрээр үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх журмаар бүдүүвч зохиож, энэ талаар ярилцана уу.

## *Сорил:*

1. Эдгээрийн аль нь Үндсэн хуулийн биелэлтийг шүүхийн бус байгууллагаас хянаж буй хяналт вэ?
  - a) Ердийн шүүхээс хянаж буй
  - b) Зөвлөл хянаж буй
  - c) Бие даасан шүүхээс хянаж буй
  - d) Үндсэн хуулийн цэцээс хянаж буй
2. Үндсэн хуулийн хяналтын загвар дахь Америк загварын онцлог аль нь вэ?
  - a) Зөвлөлөөс хянаж буй
  - b) Бие даасан шүүхээс хянаж буй
  - c) Үндсэн хуулийн цэцээс хянаж буй
  - d) Аль нь ч биш
3. Цэц үндсэн хуулийн хяналтын аль хяналтын загварт багтдаг бэ?
  - a) Америк
  - b) Герман
  - c) Франц
  - d) Зөв хариулт алга байна
4. Үндсэн хуулийг зөрчиж болзошгүй субъект
  - a) төр, түүний албан тушаалтан;
  - b) төрийн бус байгууллага;
  - c) улс төрийн нам;
  - d) иргэн, аж ахуйн нэгж.

## *Эх сурвалж:*

1. Г.Совд, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2007

## **5. Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим, тэдгээрийн төрөлтэй нэг бүрчлэн танилцаж, тэдгээрийг тайлбарлах онол, арга зүйг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар:

- Эрх зүйн зарчим
- Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим

Эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, үзэл баримтлал, зан үйлийн ерөнхий чиглэл.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах ерөнхий ба тусгай зарчмууд. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим нь аливаа шүүхийн үндсэн үйл ажиллагаа болох хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд удирдлага болгон, үзэл баримтлал болж буй чиглэмж.



### ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ЗАРЧИМ

#### Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж юу вэ?

Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд **заавал удирдамж** болгох үзэл, онолыг хуульчлан бэхжүүлсэн заалт.

#### Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим эрх зүйн хэм хэмжээнд тусгалаа олсон:

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн

2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт «Цэц нь хараат бус байху Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд эрх тэгш байх асуудлыг шударга шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх үндсэн зарчмыг баримтална» хэмээн бэхжүүлсэн.

- Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь Цэцийн үйл ажиллагааны цөм, түүний оршин байх зориулалтыг илэрхийлж байдаг.
- Нөгөөтэйгүүр үндсэн хуулийн цэц үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд заавал баримтлан ажиллах чиг баримжаа болдог.



## Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Зарчим	Зарчмын агуулга дараах байдлаар илэрнэ
Цэц хараат бус байна	<ul style="list-style-type: none"> <li>•Цэцийн шийдвэрлэсэн <b>маргаантай холбоотойгоор хариуцлага</b> хүлээлгэх албан тушаалтай байхгүй;</li> <li>•Цэцийн шийдвэрийг <b>хэн ч хянахгүй</b>;</li> <li>•Цэц бие даасан бүтэц зохион байгуулалт, төсөвтэй;</li> <li>•Цэцийн гишүүний <b>бие даасан</b> байдал түүний <b>бүрэн эрхийн баталгаагаар</b> илэрнэ (Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйл).</li> </ul>
Цэц Монгол улсын Үндсэн хуульд захирагдана	<ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн гаргаж буй шийдвэрээрээ <b>Үндсэн хуулийг тайлбарлах үнэмлэхүй эрхтэй</b> бөгөөд өөр ямар ч институт энэхүү эрхийг эдэлдэггүй;</li> <li>• Цэц маргааныг хэлэлцэхдээ <b>Үндсэн хуулийг хэрэглэдэг</b>.</li> </ul>
Гишүүд эрх тэгш байна	<ul style="list-style-type: none"> <li>•Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд <b>гишүүн бүр нэг саналын эрхтэй</b>;</li> <li>•Хэдийгээр хэд хэдэн тохиолдолд «<b>ахмад настай</b>» гишүүнийг тусгайлан авч үзэх боловч энэ нь эрхийг шууд хязгаарласан гэхээсээ илүү Монгол орны өвөрмөц онцлогтой холбоотой бөгөөд насаар ялгаварлах асуудлыг манай оронд төдийлөн гүнзгий судлаагүй байна.</li> </ul>
Асуудлыг шударга шийдвэрлэнэ	<ul style="list-style-type: none"> <li>• Маргаан хянан шийдвэрлэхдээ <b>гагцхүү Үндсэн хууль, өөрийн дотоод итгэл үнэмшилд захирагдаж</b> үндсэн хуулийн нэрийн өмнөөс асуудлыг шийдвэрлэдэг;</li> <li>• Шийдвэр гаргахад <b>үнэнийг тогтоох бүхий л нөхцөл байдлыг бүрдүүлсэн</b> байна. Энэ нь дэлхий дахинаа шүүхэд ирүүлсэн өргөдөл, гомдлын хуваарилалтыг дарга, эсвэл хэн нэг албан тушаалтан хийдэггүй харин урьдчилан тохирсон журмын дагуу хэрэгжих байдлаар илэрдэг.</li> </ul>
Үйл ажиллагаа ил тод байна	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Цэцийн хуралдаан</b> хуульд зааснаас бусад тохилдолд <b>нээлттэй явагдана</b>;</li> <li>• Шийдвэрийн агуулгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр <b>нийтэд нэн даруй мэдээлдэг</b>;</li> <li>• Гэвч маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл, шалтгаанаар хэргийн <b>бүх материалтай танилцах боломжгүй</b> бөгөөд энэ нь шүүхийн хараат бус байх зарчмаар хязгаарлагдана.</li> </ul>

### Хяналтын асуулт:

1. Цэцийн үйл ажиллагааны болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмын ялгааг тайлбарла.
2. Цэц хараат бус байх зарчмын агуулгыг жишээн дээр тайлбарла.
3. Асуудлыг шударгаар шийдвэрлэнэ гэж юуг хэлэх вэ?
4. Ил тод байх зарчмын хязгаар юунд орших вэ?



**Сорил:**

**1. Цэцийн гишүүний бүрэн эрхэнд халдах зөвшөөрлийг олгох эрх бүхий субъект**

- a) УИХ;
- b) Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага;
- c) УДШ;
- d) Үндсэн хуулийн цэц.

**2. Үндсэн хуулийн цэцийн тогтоолыг хянах эрхтэй этгээд:**

- a) УИХ;
- b) Олон улсын шүүх;
- c) хянахгүй;
- d) Ерөнхийлөгч.

**3. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааны зарчим болон маргаан хянан шийдвэрлэх зарчим хоёрын ялгааг бич.**

.....  
.....

**Эх сурвалж:**

- 1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999,
- 2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
- 3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ. 2007

**6. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, түүний эрх зүйн байдал**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүний эрх зүйн байдал, тэдгээрийн үндэслэлтэй танилцана.

**Нэр томъёоны тайлбар:**

- **Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрх зүйн байдал**
- **Үндсэн хуулийн цэцийн бүтэц, зохион байгуулалт**


Үндсэн хууль, бусад хуулиар цэцийн гишүүний бүрэн эрх, үүргийг тогтоож буй эрх зүйн зохицуулалт. Үндсэн хуулийн цэц 9 гишүүнээс бүрдэх ба ажил үүргээ танхимын зохион байгуулалтаар хуваарилдаггүй. Энэ нь түүний эрх хэмжээний онцлогтой холбоотой. Цэцийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэх нэгж нь түүний тамгын газар. Тамгын газар нь Цэцээс үйл ажиллагаагаа эрхлэн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

## • Гишүүнийг томилох

УИХ нийт ард түмний төлөөллийн байгууллага гэдэг утгаараа Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг томилдог. Томилох хэмээх нэр томъёог хэрэглэж буй шалтгаан нь сонгуулийн журмаар байгуулахад эцсийн шалгаруулалтад хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч орж тэднээс сонголт хийх боломж бүрддэг бол томилоход нэр дэвшигчийн аль нэгийг сонгоно гэсэн ойлголт байдаггүй. Нэр дэвшсэн тухайн шүүгчийг томилох эсхүл томилохоос татгалзах л боломжтой.




### ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН ШҮҮГЧ МӨН



<p><i>Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байх шалгуур нь</i></p>	<p>Цэцийн гишүүн хуульч байхын зэрэгцээ улс төрийн өндөр мэргэшилтэй байхыг тусгайлан шаарддаг. Энэ нь Цэц улс төрийн маргаанд ч хууль зүйн шийдвэр гаргадаг онцлогтой холбоотой. Нөгөөтэйгүүр шүүхэд гагцхүү шүүгчид л ажиллах шаардлагатай байдагчлан маргаангүйгээр хуульч байх ёстой.</p>
<p><i>Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэн байна гэх шалгуур нь</i></p>	<p>Цэцийн гишүүнд тавигдах хэлбэрийн шаардлага юм. Цэцийн гишүүний алба нь өндөр хариуцлагатай, иргэн байна гэх шалгуур нь туршлага шаардсан ажил тул түүний насны доод босгыг 40 нас хэмээн тогтоож өгсөн ба гишүүн Монгол Улсын иргэн байхыг мөн шаарддаг.</p>



*Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид «улс төрийн мэдлэгтэй байх» шалгуур тавигдах гол шалтгаан нь:*





- Үүгээрээ Үндсэн хуулийн шүүх ердийн болон дагнасан шүүхээс ялгагдана.

*Үндсэн хуулийн шүүхэд хэн ажиллах вэ?*

Шүүх өөрөө хуулийг хэрэглэдэг тул түүнд ажиллах этгээд **гагцхүү шүүгч** байна.

*Монгол Улсын хувьд шүүгчид тавигдах болзол нь:*



## Шүүгчид тавигдах шаардлага юунд ач холбогдолтой вэ?


Хуульд заасан шаардлагыг хангасан шүүгчээр шүүлгэх эрхтэй гэх эрх зүйн зарчмыг хангах зориулалттай



### ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ


Үдсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн нэг: «Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилоно».

### Цэцийн гишүүнийг томилох процедур:






*Цэцийн гишүүнийг томилохоос татгалзсан болон нөхөн томилох тохиолдолд:*




**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

*Цэцийн гишүүний бүрэн эрх нь:*



*Цэцийн гишүүн дахин томилогдох боломжтой эсэх:*



## Шүүгчийн хараат бус байдлын нэг чухал зүйл нь:

**Парламентаас хараат бус байх шаардлагатай**


Хэрэв хууль тогтоогчоос хараат байвал түүнд хяналт тавих гол үүргээ биелүүлж үл чадна. Үүний өвөрмөц нэг тохиолдол бол цэцийн гишүүн хуулийг батлахад **таслах эрхтэйгээр оролцсон** байх явдал байдаг. **Таслах эрхтэйгээр оролцсон** нь тухайн шийдвэрийг боловсруулах, хэлэлцэх, санал хураах ажиллагаанд оролцож өөрийн байр суурийг илэрхийлж байсныг ойлгоно. Уг нөхцөл байдлыг ҮХЦМХШАТХуулийн 2005 нэмэлт, өөрчлөлтөөр зохицуулсан.

## Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа:

Үндсэн хуулийн цэцийн гишүүний халдашгүй байдал

- Цэцийн гишүүнийг баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, Эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд захиргааны шийтгэл оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.
- Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Дээрхээс бусад тохиолдолд бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө уг албан тушаалаас чөлөөлөх, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно.
- Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хугацаагаар Цэцийн гишүүнээс чөлөөлөгдсөн хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтооно.

## Цэцийн үйл ажиллагааны нөхцөл ба цэцийн зохион байгуулалт:





### Цэцийн гишүүн ажил хавсран гүйцэтгэж болох эсэх:

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3.5 дах хэсэгт «... Цэцийн гишүүн Засаг захиргаа, нам-улс төрийн болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж үйлдвэрчний эвлэлийн удирдах ажил хийж болохгүй» гэж зохицуулсан. Үүнээс үзвэл дээрх төрөлд хамаарах ажлыг бүрэн эрхийн хугацаандаа эрхлэх боломжгүй болох юм.

**Үүний нэг жишээ нь Цэцийн гишүүн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй юм.**

Хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг зохицуулж буй хуулиудаар шууд хориглоогүй боловч **ШҮҮГЧ гэх агуулгаар** Өмгөөллийн тухай хуулиар **хориглосон** байдаг.

### Хяналтын асуулт:

1. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шалгуур юу вэ? Бусад орны шүүгчийн шалгууртай Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах шалгуурыг харьцуулах.
2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох процедурын талаар ярилц.
3. Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалтын онцлог юу вэ?
4. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход улс төрийн болон мэргэжлийн байгууллагын оролцоо ямар байх вэ?

### Сорил:

#### №1

Үндсэн хуулийн цэцийн гишүүн «А» нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг. Гэтэл анхан шатны шүүхээр маргаан хэлэлцэх явцад хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн байх шинжтэй байжээ. Тухайн шатны шүүх УДШ-д хандсан ба УДШ уг хууль Үндсэн хууль зөрчиж буй эсэхийг тогтоолгохоор Цэцэд хүсэлт гаргасан байна. Үндсэн хуулийн цэц уг хуулинд холбогдох заалтыг хүчингүй болговол «А»-ын өмгөөлж буй хэргийг шүүхээс шийдвэрлэхэд нөлөөлөхүйц байжээ.

## Асуулт:

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн «А»- нь энэ хэрэгт өмгөөлөгнөөр оролцож болох уу?

## №2

ҮХЦ-ийн дарга Д нь энэхүү ажлаа эрхлэхээс өмнө УИХ-ын гишүүн байсан. Түүний УИХ -ын гишүүний сонгуульт хугацаа дуусгавар болсны дараагаар ҮХЦ-ийн гишүүнээр томилогдож, даргаар сонгогдсон. Д нь УИХ-ийн гишүүн байх явцдаа Эрүүгийн хуулийн нэмэлтийн тухай хуулийг бие даан санаачилж УИХ -аас баталсан байна. Гэтэл уг нэмэлтийн тухай хуулийн нэгэн заалт Үндсэн хуулийг зөрсөн тухай нэгэн иргэн мэдээлэл гаргасан байна.

## Асуулт:

1. Үндсэн хуулийн цэцийн дарга Д нь тус ажлыг эрхлэн гүйцэтгэж болох уу? Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад харшлах зүйл бий юу?

## Эх сурвалж:

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл., УБ, 2007
3. М.Батсуурь, Ч.Өнөрбаяр. Эрх зүйт ёс. УБ. 2010

## 7. Цэцийн эрх хэмжээ, харьяалан шийдвэрлэх асуудал

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ, хяналтын объект, түүний төрөл, хэлбэртэй танилцна.


### Нэр томъёоны тайлбар:

- **Хяналтын объект** Үүнд үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх объект (шийдвэр, үйл ажиллагаа) хамаарна. Үүнд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй институт болох хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хамаардаг.
- **Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан** Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, ҮХЦМХШАТХуулийн 13, 14 дүгээр зүйлд зохицуулсан. Тодорхой төрийн байгууллагын буюу албан тушаалтны төрийн
- **Эрх хэмжээ** байгууллагын тогтолцоонд эзлэх байр суурийг тодорхойлсон, хуульчлан тогтоосон эрх, үүргийн нийлбэр цогц.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ БА ХЯНАЛТЫН ОБЪЕКТ

*Үндсэн хуулийн шүүхийн хяналтын сонгодог ойлголт:*




*Үндсэн хуулийн хяналт нь Үндсэн хуулын ёсыг бэхжүүлнэ:*



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН МАРГААНЫ ХАРЬАЛАЛ

Үндсэн хуулийн цэц үндсэн хуульд дээд хяналт тавих субъект Энэ ч үүднээс түүний хяналтын **цар хүрээг Үндсэн хуулиар** тогтоодог. (Үүнийг *Үндсэн хуулийн Жаран зургаадугаар зүйлийн 2 дах хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 3 дах хэсэг, ҮХЦМХШАТХуулийн 13, 14 дүгээр зүйлд зохицуулсан.*)


Үндсэн хуулийн цэцийн хяналтын объектыг:






**Шийдвэр, үйл ажиллагааны ялгаа нь:**

**Цэцийн маргааны харьяаллыг Үндсэн хуулийн шүүхийн сонгодог харьяаллаас ялгаатай тогтоосон:**



Иймд шийдвэр үйл ажиллагаа нь шууд бие биендээ нөхцөлдсөн байдаг.



Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэр бүхэлдээ хамаарч байна. Харин гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны шийдвэрээс Ерөнхийлөгч, Засгийн газар болон СЕХ-ны шийдвэрийг л хянадаг.

Шүүх эрх мэдлийн шийдвэр хамаарахгүй байгаа нь Үндсэн хуулийн шүүхийн сонгодог ойлголтоос зөрүүтэй байна.

Үндсэн хуулийн шүүхийн сонгодог ойлголт ёсоор Үндсэн хуулийн шүүх ердийн болон дагнасан шүүхийн шийдвэрийг хянадаг. Энэ нь шүүх эрх мэдлийг дахин шүүх асуудал огтхон ч биш бөгөөд харин түүний гаргах шийдвэр Үндсэн хуулийн үндсэн эрхийн утга агуулгад бүрнээ нийцэх асуудал юм.

## *Хяналтын асуулт:*

1. Үндсэн хуулийн цэц хууль, УИХ-ын бусад шийдвэрт хяналт тавьж буй ардчилсан ёсны зарчмын агуулгыг хөндөж буй хэрэг мөн үү?
2. Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр захиргааны хэргийн шүүхийн хяналтын объект болох уу?
3. Ердийн болон дагнасан шүүхийн шийдвэрийг Цэц хянан шийдвэрлэх үү?
4. Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг ердийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаанаас ялга.

## *Сорил:*

### **№1**

Иргэн Л Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөлөх тусгай зөвшөөрлийг авчээ. Гэтэл Монголын өмгөөлөгчдийн холбооноос Л удаа дараа түүний гаргасан сахилгын зөрчилтэй нь холбогдуулан сахилгын шийтгэл оногдуулжээ.

Улмаар 2007 оны 12 дугаар сард Л-ийн өмгөөллийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг Монголын өмгөөлөгчдийн холбооноос ХЗДХ сайдад санал оруулсан бөгөөд уг саналыг үндэслэн ХЗДХ сайд 2007 оны 38 дугаар тушаалаараа Л-ийн өмгөөллийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон шийдвэрлэсэн байна.

Л өөрийн өмгөөллийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болсныг 7 хоногийн дараагаар өдөр тутмын сонин дээрээс олж мэджээ.

### **Асуулт:**

1. Энэхүү тохиолдол Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн үү?
2. Энэхүү нөхцөлд Монгол улсын Үндсэн хуулийн цэц маргааныг хянан шийдвэрлэх үү?

### **№2**

Монгол Улсын Их Хурал 2008 оны 03 дугаар сарын 27-ны өдөр «Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль»-ийг батлан гаргажээ. Тус хуулийн 27 дугаар зүйлд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг зохицуулжээ.

Ингэхдээ хуулийн 27.3 дах хэсэгт «Ял шийтгэлгүй байх» нөхцөлийг тусгасан байна.

Гэтэл 2008 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын дээд шүүхээс Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дах хэсгийг тайлбарласан.

Тус тайлбарт 27.4.3,-т заасан «**ялгүй байх**» гэдгийг Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан «**ялгүйд тооцох**», «**ялгүй болох**» гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй тул үүнийг өмнө нь огт «**ял шийтгүүлж байгаагүй**» гэж ойлгон хэрэглэнэ хэмээн зохицуулсан байна.



Гэтэл иргэн Б УИХ-аас батлан гаргасан Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 27.3 дах хэсэгт заасан «Ял шийтгэлгүй байх» гэх заалт өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна хэмээн үзэж Үндсэн хуулийн цэцэд ханджээ.

**Асуулт:**

1. Энэхүү тохиолдол Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан болох уу? Яагаад?
2. Энэхүү нөхцөлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц маргааныг хянан шийдвэрлэх үү?

**Сорил:**

**1. Аль нь Үндсэн хуулийн цэцийн хяналтын объектод хамаарах вэ?**

- a) Иргэдийн өргөдөл, мэдээлэл
- b) Албан тушаалтны хүсэлт
- c) Ард нийтийн санал асуулгатай холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр
- d) Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр (УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой)

**2. Цэц аль төрлийн маргааныг хянан шийдвэрлэх вэ? (Үл хамаарахыг ол)**

- a) Сонгуулийн төв байгууллагын орон нутгийн сонгуультай холбоотой шийдвэр
- b) Сонгуулийн төв байгууллагын УИХ-ын сонгуулийн үр дүнтэй холбоотой шийдвэр
- c) Улсын дээд шүүхийн тогтоол
- d) Сонгуулийн төв байгууллагын ард нийтийн санал асуулгатай холбоотой шийдвэр

**3. Цэц аль албан тушаалтныг огцруулах болон эргүүлэн татах үндэслэл байгаа талаар дүгнэлт гаргах боломжгүй вэ?**

- a) Засгийн газрын гишүүн;
- b) Монгол улсын Ерөнхийлөгч;
- c) УИХ-ын гишүүн;
- d) Ерөнхий сайд.

**Эх сурвалж:**

1. Г.Совд, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
3. Монгол Улсын үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ. 2007

## ГУРАВ. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

**Бүлгийн зорилго:** Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий субъект, тэдгээрийн эрх зүйн байдал, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, үе шат, тэдгээрийг тайлбарлах онол, арга зүйг эзэмшинэ.

### 8. Цэцэд хандах эрх бүхий субъект

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий субъектийн эрх зүйн байдал, тэдгээрийн онцлог шинжтэй танилцана.

#### *Нэр томъёоны тайлбар:*


- **Монгол Улсын иргэн:** Монгол Улсын иргэний харьяалал бүхий бие хүн. Монгол Улсын иргэн нь Монгол улсын иргэний харьяатыг нотлох бичиг баримттай байна.
- **Гадаадын иргэн:** Гадаад улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой этгээд. Түүний эрх зүйн байдал оршин суугаа улсын үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр тодорхойлогдоно.
- **Харьяалалгүй хүн:** Аль нэг улсын иргэний харьяалалд хамаарах эсэхийг тогтоож болохуйц холбогдох нотлох баримт байхгүй этгээд.
- **Хуулийн этгээд:** Иргэний эрх зүйн субъект бөгөөд өөрийн өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй өөрийн нэрээр эрх, эдэлж үүрэг хүлээх зохион байгуулалт бүхий нэгж.
- **Нийтийн эрх зүйн хуулийн этгээд:** Нийтийн болон хувийн эрх зүйн аль ч салбарт эрх зүйн чадвар, чадамжтай, хуулиар эсвэл хуульд заасны дагуу эрх шилжүүлснээр байгуулагдан төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцож байдаг субъектууд.
- **Өргөдөл:** Үндсэн хуулийн шүүхэд иргэдийн хандах хэлбэр. Үндсэн хуулийн шүүхэд **өөрт хамааралтай асуудлаар** хандан гаргаж буй гомдол болдог. Үндсэн хуулийн цэцийн харьяаллын байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар Үндсэн хуульд заасан аль нэг үндсэн эрх иргэнд өөрт нь хамааралтайгаар зөрчигдөж байна гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргана.
- **Мэдээлэл:** Үндсэн хуулийн шүүхэд иргэдийн хандах хэлбэр. Мэдээлэл нь **өөрт хамааралтай байх** шинжийг агуулахгүй. Тодруулбал: Үндсэн хуулийн цэцийн харьяалалд хандах, хамаарах дурын асуудлаар хандаж болно. Үндсэн хуулийн зүйл заалтыг тухайн хууль зөрчиж байна хэмээн хандаж буй нь мэдээллийн дагуу хандаж буй хэлбэр юм.
- **Хүсэлт:** Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуульд заасан байгууллага, албан тушаалтан хандах хэлбэр. Энэ нь албан шугамаар хандаж байгаа ажиллагаа байдаг.



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ХАНДАХ НЬ

**Монгол улсын  
Үндсэн хуулийн**

Жаран зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт:  
«Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн  
тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн  
дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их  
Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд  
шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр  
хянан шийдвэрлэнэ» хэмээн зохицуулсан.








## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД БУСАД ЭТГЭЭД ХАНДАХ НЬ

### Бусад этгээд

Үндсэн хуульд заасны дагуу нэр бүхий байгууллага, албан тушаалтнууд Үндсэн хуулийн цэцэд хандаж болно.

### Цэцэд хандах байгууллага, албан тушаалтан нь:



Эдгээр байгууллага, албан тушаалтны Үндсэн хуулийн шүүхэд хандах нэг сонгодог нөхцөл нь **маргаж буй асуудал хандаж буй этгээдэд хамааралтай** байх явдал боловч Үндсэн хуулийн цэцэд харьяаллынх нь аль ч асуудлаар хандах боломжтой байхаар зохицуулсан байдаг.

### Хяналтын асуулт:

1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Үндсэн хуулийн цэцэд хандаж болох уу?
2. Үндсэн хуулийн цэцэд иргэн хүсэлт гаргаж болох уу?
3. Өргөдөл, мэдээллийн ялгааг тайлбарла.
4. Албан тушуултан үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргах эрхтэй юу?

### *Сорил:*

1. Иргэн А УИХ-ын сонгуульд нэр дэвшжээ. Санал хураалтаар тэрээр маш бага саналын зөрүүтэйгээр ялагдсан. Сонгуулийн дараагаар А УИХ-ын сонгуулийн тухай хуулийн санал тоолохтой холбоотой хэд хэдэн заалт Үндсэн хууль зөрчиж буй болохыг анзаарч Үндсэн хуулийн цэцэд ханджээ. Энэ тохиолдолд А-ийн Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан гомдол ямар хэлбэртэй байх вэ?
  - e) А өргөдөл гаргасан
  - f) А мэдээлэл гаргасан
  - g) А хүсэлт гаргасан
  - h) А нэхэмжлэл гаргасан
  
2. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй субъект аль нь вэ?
  - a) Тагнуулын төв байгууллагын дарга
  - b) Сонгуулийн төв байгууллагын дарга
  - c) Цагдаагийн ерөнхий газрын дарга
  - d) Зөв хариулт алга байна
  
3. Эдгээр субъектуудын аль нь Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах вэ?
  - a) Албан тушаалтан
  - b) Иргэн (хүн бүр)
  - c) Хуулийн этгээд (хувийн эрх зүй дэх)
  - d) Дээрх бүгд
  
4. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрхтэй албан тушаалтан
  - a) Ерөнхийлөгч
  - b) УИХ-ын дарга
  - c) УДШ-ийн Ерөнхий шүүгч
  - d) Сонгуулийн хорооны дарга

### *Эх сурвалж:*

1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005
3. Монгол Улсын үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ. 2007



## 9. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, түүний төрөл, хэлбэртэй нэг бүрчлэн танилцана.

**Нэр томъёоны тайлбар:**

- **Шүүгчийн тусгай санал:**

Үндсэн хуулийн шүүхийн зөвлөлдөх тасалгаанд олонтой санал нийлээгүй шүүгч «тусгай саналаа- dissenting opinion» өөрөө хүсвэл бичгээр гаргах эрхтэй байдаг. Үүнийг шийдвэрийн хамт хэвлүүлж нийтийн хүртээл болгодог. Хэдийгээр энэ нь эрх зүйн хувьд шууд үр дагавар үүсгэхгүй боловч шүүхийн практик болон Үндсэн хуулийн процессын эрх зүйн судалгаанд онцгой ач холбогдолтой. Манай улсын хувьд тусгай саналыг бичгээр гаргаж болох боловч түүнийгээ зөвхөн зөвлөлдөөний тэмдэглэлд хавсаргах эрхтэй.

- **Төлөөлөл:**

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийг хуульд заасны дагуу өөрийнх нь хүсэлтээр өөр этгээд төлөөлөн оролцох боломжтой. Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгч төлөөлнө.

- **Бүрэн төгс байх зарчим:**

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээ нь бүхий л харилцааг зохицуулж үл чадна. Иймд процессын эрх зүйн бусад хэм хэмжээг «төсөөтэй» хэрэглэх шаардлага бий болдог.

- **Хянан магадлах зарчим:**

Үндсэн хуулийн шүүх нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг. Нийтийн эрх зүйн маргааны нэг онцлог нь эрх тэгш бус субъектууд оролцож байдагт оршино. Нэг талд байгууллага, албан тушаалтан, нөгөө талаас иргэн оролцсон тэгш бус харилцааг тэнцвэржүүлэх нэг арга юм. Энэхүү зарчим нь хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай **нотлох баримтыг шүүх өөрөө албан шугамаар олж бүрдүүлэх** байдлаар илэрнэ.

- **Диспозицийн зарчим:**

Үндсэн хуулийн шүүхийн хувьд маргаан нь тодорхой нэг эсвэл хэд хэдэн хүнд хамаатай байгаад зогсохгүй **нийтийн ашиг сонирхлыг хөндөж байдаг**. Иймд өргөдөл, мэдээлэл, гомдол гаргагч шаардлагаасаа татгалзсан тохиолдолд ч **түүнийг цааш хянан шийдвэрлэх ёстой** гэж үздэг. Энэ зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаандаа удирдлага болгодоггүй.

## 9.1. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим



**ЦЭЦ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХДЭЭ ШҮҮХЭЭД  
УДИРДЛАГА БОЛГОДОГ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ БАРИМТЛАНА**

Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим нь

Цэц маргаан хянан шийдвэрлэхдээ шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхэд баримталдаг **ерөнхий зарчмуудыг нэгэн адил** удирдлага болгоно. Түүнчлэн цэцийн үйл ажиллагааны **өвөрмөц шинж чанараас хамааран тусгай зарчмууд үйлчилдэг.**



Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-12 дугаар зүйлд дээрх зарчмууд тусгалаа олсон байдаг.

*Эдгээр зарчмыг дэлгэрүүлэн авч үзвэл:*

ЗАРЧИМ	АГУУЛГА
Маргааныг ил тод хянан шийдвэрлэх	Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах онцгой шаардлагатайгаас бусад тохиолдолд <b>Цэцийн хуралдааны нээлттэй</b> явуулах байдлаар уг зарчим хэрэгжинэ.
Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үгчилж явуулах	Цэцийн хуралдаанд маргагч талуудын тайлбар, дүгнэлт, санал, хүсэлт, мэтгэлцээнийг <b>үгээр сонсох</b> бөгөөд шийдвэр гаргахад шаардлагатай болон маргагч талуудын хүссэн бичиг баримт, материалыг нэг бүрчлэн <b>уншиж сонгох байдлаар</b> хэрэгжинэ.
Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулах	Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг <b>монгол хэлээр явуулна</b> . Оролцогчид Монгол хэл мэдэхгүй тохиолдолд мэдүүлэг, дүгнэлт, тайлбараа төрөлх буюу сайн мэдэх хэлээрээ гаргаж <b>хэлмэрчлүүлэх, орчуулуулах</b> байдлаар энэ зарчим хэрэгжинэ.



<p><b>Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг биечлэн явуулах</b></p>	<p>Хуралдааныг хуулиар тогтоосон журмындагуу томилогдсон бүрэлдэхүүнээр <b>эхнээс нь дуусах хүртэл биечлэн явуулах</b> бөгөөд бүрэлдэхүүнд оролцсон гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй бол түүний оронд Цэцийн өөр гишүүнийг нөхөн томилж хуралдааны ажиллагааг <b>эхнээс нь дахин шинээр явуулах</b> байдлаар илэрнэ.</p>
<p><b>Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулах</b></p>	<p>Цэцийн хуралдаан болон зөвлөлдөөн хууль тогтоомжид заасан амралтын цагаас бусад <b>хугацаанд тасралтгүй явагдана</b>. Цэцийн хуралдаан завсарласан хугацаанд <b>өөр төрлийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй</b>.</p>
<p><b>Мэтгэлцэх</b></p>	<p>Маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгчид маргаж байгаа асуудлаар харилцан бие биедээ асуулт тавьж, хариулт авах, гомдлын шаардлага, татгалзлалын үндэслэл болсон <b>нотлох баримтуудыг харилцан няцаах</b>, энэ талаарх баримтуудыг <b>зохих журмын дагуу гаргах, батлах зэргээр</b> мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлнэ гэж хуульд заасан байдаг. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хуралдааныг даргалагч удирдан явуулдаг, гишүүд асуулт тавьж хариулт авдаг зэргээс харахад дэлхийн улсуудын үндсэн хуулийн шүүхүүдийн мэтгэлцэх зарчим биш, түүний оронд хянан магадлах зарчим хэрэгжиж байна.</p>
<p><b>Цэц нууц зөвлөлдөх</b></p>	<p>Цэцийн шийдвэр гаргах гишүүдийн зөвлөлдөөнийг <b>тусгай тасалгаанд хийнэ</b>. Цэцийн зөвлөлдөөн хийж байгаа тасалгаанд хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд, зөвлөлдөөний тэмдэглэл хөтлөх хуралдааны нарийн бичгийн даргаас өөр хүн орохыг хориглоно. Зөвлөлдөх <b>тасалгаанд гишүүдийн гаргасан саналыг задруулахыг хориглоно</b> гэж хуульд заасан. Бусад шүүхээс ялгаатай нь зөвлөлдөх тасалгаанд хуралдааны нарийн бичгийн дарга оролцдог.</p>
<p><b>Цэцийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх</b></p>	<p>Цэцийн шийдвэр нь Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтын үг үсэг, утга санаанд бүрэн нийцсэн нөхцөлд <b>хууль ёсны болно</b>. Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлуудыг хуралдааны үед бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, гарах дүгнэлтийг нотлох баримтуудаар хангалттай баталсан нөхцөлд Цэцийн шийдвэр <b>үндэслэлтэй болно</b>.</p>
<p><b>Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хараат бус байх</b></p>	<p>Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, бусад иргэнээс хараат бус байж, гагцхүү <b>Үндсэн хуульд захирагдан, дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэнэ</b>. Цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааны талаарх саналаа урьдчилан хэлэх, энэ талаар бусдад <b>зөвлөгөө өгөх эрхгүй</b>.</p>


## 9.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай зарчим



ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХДЭЭ  
ТУСГАЙ ЗАРЧИМ БАРИМТАЛНА:



Эдгээр зарчмыг дэлгэрүүлэн авч үзвэл:





### Өргөдөл буцаах

Харьяаллын бус, үндэслэлгүй өргөдөл, мэдээллийг үндсэн хуулийн шүүх буцаах эрхтэй. Үүнийг шүүхийн хуралдааны ачааллыг хөнгөлөх үүднээс авч буй арга хэмжээ гэж тооцдог.

### Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг амаар явуулах

Шүүх хуульд өөрөөр заагаагүй бол маргааныг амаар явуулах нийтлэг журамтай байдаг. Гэвч аман хуралдаан хийснээр зөв шийдвэр гаргах зүйлийг олж тогтоох боломжгүй гэж үзсэн, маргагч тал болох үндсэн хуулийн шинжтэй байгууллага өөрсдийгөө амаар мэдүүлэх шаардлагагүй гэж үзсэн бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудыг оролцуулалгүй явуулдаг туршлага зарим улсад байдаг.

Ердийн шүүхийн хувьд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэхэмжлэгчийн нэмжлэлийн шаардлагын хүрээнд хязгаарлагддаг бөгөөд түүнийг дуусгавар болгох **гагцхүү түүний хүсэл зоригоос л хамаардаг**. Гэтэл үндсэн хуулийн шүүхийн хувьд маргаан нь нэг тодорхой хүнд хамаатай бус харин **нийтийн ашиг сонирхлыг хөндөж байдаг**. Иймд гомдол гаргагч өөрийн гомдлоос татгалзсан тохиолдолд ч **түүний цааш хянан шийдвэрлэх боломжтой** байдаг.

### Диспозицийн зарчим

Диспозицийн зарчим Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгждэггүй.

### Хяналтын асуулт:

1. Тусгай саналыг хэн гаргах вэ?
2. Бүрэн төгс бус байх зарчмын агуулга юу вэ?
3. Хянан магадлах зарчим нь ердийн болон дагнасан шүүхэд хамаарах уу?
4. Диспозицийн зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц яагаад хэрэглэдэггүй вэ?

### Эх сурвалж:

1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005

3. Монгол улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ 2007

### 10. Цэцийн хуралдаанд бэлтгэх, түүний үе шат

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх, цэцийн хуралдаанд бэлтгэх үе шат, тэдгээрийн онцлогыг судалж, шаардлагатай баримт бичгийн төслийг боловсруулах дадал, чадварыг олж авна.

#### *Нэр томъёоны тайлбар:*

• **Маргаан үүсгэх:** Өргөдөл, мэдээлэл, хүсэлт нь хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргана. Мөн бага суудлын хуралдаанаас маргаан үүсгэх тухай магадлал гарсан тохиолдолд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ.

• **Тогтоол:** Цэцээс гаргаж буй шийдвэрийн хэлбэр. Тогтоолыг Цэцийн гишүүн маргаан үүсгэх болон үүсгэхээс татгалзах асуудлаар, мөн их суудлын хуралдаантай бүрэлдэхүүнээс Цэцийн харьяалан шийдвэрлэх байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хүчингүй болгох эсэх асуудлаар гаргана.

#### 10.1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх гишүүний ажиллагаа



ГИШҮҮН ЦЭЦЭД ХАНДАН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, МЭДЭЭЛЭЛ,  
ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАХ

#### *Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах:*

**Цэцэд ирсэн гомдлын дагуу эн тэргүүнд**

Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн **иргэдийн** өргөдөл, мэдээлэл, албан тушаалтны хүсэлтийг хүлээн авмагц Үндсэн хуулийн **цэцийн дарга** Цэцийн аль нэг гишүүнд **хуваарилна.**



Цэцэд ирүүлэх өргөдөл, мэдээлэл, хүсэлт дараах шаардлагыг хангасан байна.

**1.Өөрийн нэр, хаяг, оршин суугаа газар, харилцах хэлбэр**

2.Түүний итгэмжилсэн төлөөлөгч буюу өмгөөлөгчөөр оролцох хүний нэр, хаяг, албан тушаал, бусад шаардлагатай мэдээлэл

3. Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомжийн нэр> батлан гаргасан он, сар, өдөр, дугаар, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа албан тушаалтны нэр, хаяг үйл ажиллагааны талаар

4.Өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоо

5. Маргаж байгаа асуудлын талаарх өөрийн байр суурь


**6.Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлага**

7. Үндсэн хууль болон энэ хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг үндэслэн Цэцэд хандаж байгаа


8. Хавсаргасан бичиг баримт болон холбогдох хүмүүсийн нэрсийн жагсаалт, тодорхой хаяг

Дээрх шаардлагыг хангаагүй өргөдөл, мэдээлэл болон хүсэлтийг ЦЭЦ хүлээн авахгүй.


*Өргөдөл, мэдээлэл, хүсэлттэй холбоотой гишүүний ажиллагаа:*



## Өргөдөл, мэдээлэл хүлээн авах гишүүний ажиллагаа:




## Гишүүн маргаан үүсгэх болон үүсгэхээс татгалзсан тогтоол гаргасны учир холбогдол:





### Хүсэлт хүлээн авах гишүүний ажиллагаа:





### 10.2. Цэцийн хуралдаанд бэлтгэх ажиллагаа



#### ЦЭЦИЙН ХУРАЛДААНД БЭЛТГЭХ НЬ

Хуралдаанд бэлтгэх ажиллагааг эрхлэн явуулах нь:





*Хуралдаанд бэлтгэх үе шат:*

Хуралдаанд бэлтгэх үе шат	1. Маргагч талуудад өргөдөл, мэдээлэл хүсэлт, гомдлын, хуулбарыг гардуулж, маргаанд оролцох итгэмжилсэн төлөөлөгчөө томилох тухай мэдэгдэх
	2. Маргагч талуудад хуульд заасан эрх, үүргийг танилцуулж, Цэцэд шинээр нотлох баримт гаргахад нь туслах
	3. Маргагч талууд болон тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгчийг асууж, тайлбар, тодорхойлолт гаргуулах
4.Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой бичиг баримт, бусад мэдээллийг шаардан гаргуулах	5. Маргаантай холбогдол бүхий албан тушаалтан бусад хүмүүсийг асууж тодорхойлолт авах
6.Шаардлагатай бол эрдэмтэн, мэргэжилтэн оролцуулах, тусгай мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах, дүгнэлт гаргуулах	7. Гэрчээс тодорхойлолт авах
8.Нэг асуудлаар хоёр буюу хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт байгаа бол тэдгээрийг нэгтгэх, нэг өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд хоёр буюу хэд хэдэн өөр шаардлага тавьсан бол тэдгээрийг тусгаарлах тогтоол гаргах	9. Маргагч талууд харилцан ойлголцож өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал нь шаардлагаасаа сайн дураараа татгалзвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг татгалзах тогтоол гаргах
10. Цугларсан бичиг баримтад үндэслэн Цэцир хуралдааны шийдвэрийн гэмдэглэх, тодорхойлох хэсгийн төслийг бэлтгэх	11. Маргааныг бүрэн гүйцэд, бодитой шийдвэрлэхэд шаардагдах бусад бэлтгэл ажиллагаа



**Хуралдаанд  
бэлтгэх гишүүний  
үүрэг нь**

Цэцийн гишүүн бэлтгэх ажиллагааг гүйцэтгэж дууссаны дараагаар холбогдох материалуудыг хуралдааны бүрэлдэхүүн бэлтгэж тараадаг. Маргааныг шийдвэрлэхээр томилогдсон гишүүд хуралдаан эхлэхээс өмнө тухайн асуудлын талаар адил тэгш хэмжээний мэдээлэл авсан байх шаардлагатай байдаг.

**Хяналтын асуулт:**

1. Иргэн өөрийн үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар цэцэд хэрхэн хандах вэ?
2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тайлбарла.
3. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхэд цэцийн гишүүн хэрхэн оролцох вэ?

**Сорил:**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД  
ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ**

*Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар*

Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн өмгөөлөгч асан «Л» би Өмгөөллийн тухай Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.2-т заасан үйлчлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүх арга хэрэгслийг ашиглан бүрэн, тууштай хамгаалах үүргээ шударгаар биелүүлснийхээ төлөө Сүхбаатар дүүргийн шүүхээс нэг төрлийн фактад захиргааны шийтгэлийг давхардуулан оногдуулсныг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооноос хөөн хэлэлцэх хугацаа дууссан хойно сахилгын шийтгэл оногдуулахаар Монголын Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооноос гаргасан 7 дугаар тогтоолыг хүчингүй болгуулахаар 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд «О» хандаж өргөдөл гаргасан балээ. Гэтэл Хууль зүй, дотоод хэргийн сайд «О» нь 2006 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 48 дугаар тушаалаараа миний өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2006 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосныг Монголын Өмгөөлөгчдийн холбоонд хүргүүлсэн хувиас мэдсэн болно. Энэхүү тушаалыг гаргаснаараа сайд «О» нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12-т заасан «Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй, төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй» гэсэн заалтыг зөрчиж, Үндсэн хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй байна. Дүгнэлт гаргаж өгнө үү.

## *Асуулт:*

1. Энэ тохиолдолд цэц өргөдлийг хүлээн авах уу? Яагаад?
2. Үндсэн хуулийн цэцийн гишүүн хуралдаанд бэлтгэх ажиллагаа явуулах үндэслэл байна уу?

## *Эх сурвалж:*

1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999.
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005.
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2007.

## **11. Маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, Цэцийн шийдвэр, түүний төрөл**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, шийдвэрийн төрөл, тэдгээрийн эрх зүйн үр дагавартай танилцана.

### *Нэр томъёоны тайлбар:*

- **Бага суудал:** Тус хуралдаанаар өргөдөл, мэдээллийн **шаардлагыг хангах эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй** харин Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг **үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг**. Гурван гишүүний бүрэлдэхүүнтэй хуралддаг.
- **Их суудал:** Маргааныг **эцэслэн шийдвэрлэх** хуралдаан. Маргааныг дахин хянан шийдвэрлэх буюу **магадлан шийдвэрлэнэ. Мөн албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх** асуудлыг 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.
- **Магадлал:** Бага суудлын хуралдаанаас гарах шийдвэр.
- **Дүгнэлт:** Дунд суудлын хуралдаанаас гарах шийдвэр.
- **Тогтоол:** Цэцийн гишүүний гаргах шийдвэр. Мөн Цэцийн харьяаллын байгууллага, албан тушаалтны шийдвэрийн талаарх маргааныг магадлан шийдвэрлэсэн их суудлын хуралдаанаас гарах шийдвэр.




### 11.1. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны **БАГА СУУДАЛ**

- Бүрэлдэхүүн:** Гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тус бүрэлдэхүүнд маргааныг урьдчилан шалгасан гишүүн орохгүй.
- Онцлог:** Тус хуралдаанаар өргөдөл, мэдээллийн **шаардлагыг хангах эсэх асуудлыг шийдвэрлэдэггүй.**
- Хуралдааны шийдвэрлэх асуудал:** Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг **үүсгэх эсэх талаар гаргасан Цэцийн гишүүний шийдвэрийг** эс зөвшөөрсөн тохиолдолд хийнэ.
- Гаргах шийдвэр:** Өргөдөл, мэдээллийн дагуу маргаан үүсгэх эсэх асуудлаар гаргасан Цэцийн гишүүний тогтоолыг хэлэлцэн **магадлал** гаргана. **Ердийн олонхийн** саналаар шийдвэр гаргана

*Бага суудлын хуралдаан нь:*




### 11.2. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дунд суудал


Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны **ДУНД СУУДАЛ**

- Бүрэлдэхүүн:** **Таван** гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- Онцлог:** Цэцийн хаяялан шийдвэрлэх байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн талаар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг анхлан хянан шийдвэрлэнэ.
- Хуралдааны шийдвэрлэх асуудал:** Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд дурдагдсан маргааныг хянан шийдвэрлэнэ.
- Гаргах шийдвэр:** Маргаантай шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэж **Ердийн олонхийн** саналаар **дүгнэлт** гаргана.

## Дунд суудлын хуралдаан нь:



## Дунд суудлын хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр болох нь:





**Дунд суудлын  
хуралдааны алдааны  
шийдвэрийг УИХ-д  
оруулдаг нь**

- УИХ буюу маргалдагч талд алдаагаа засах боломжийг олгох;
- Тухайн тодорхой актын Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж буй хэсгийг гаргах болсон үндэслэл, шалтгааны талаар хууль тогтоогчид өөрийгөө илэрхийлэх боломжийг олгох зорилготой.

- Үндсэн хуулийн зөрчилтэй акт нийгэмд үйлчлэх явдлаас сэргийлэх;
- УИХ-аас цэцийн дүгнэлийг хуульд заасан хугацаанд хэлэлцэх, хууль тогтоогч үйл ажиллагаандаа хууль дээдлэх зарчмыг хэвшүүлдэг болоход чухал ач холбогдолтой.

**Дүгнэлт гаргасантай  
холбоотойгоор актын  
биелэлт түтгэлзэх нь:**

### 11.3. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны их суудал

**Бүрэлдэхүүн:** 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.


**Онцлог:**

**Хуралдааны шийдвэрлэх асуудал :** Маргааныг дахин хянан шийдвэрлэх буюу **магадлан шийдвэрлэж эцсийн шийдвэр гаргана. Албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх түүнийг огцруулах, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл байгаа эсэх талаар хянан шийдвэрлэнэ.**

**Гаргах шийдвэр :** Маргааныг **эцэслэн шийдвэрлэж тогтоол мөн албан тушаалтан үндсэн хууль зөрчсөн түүнийг огцруулах, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана. Тогтоолыг дийлэнх олонхийн дүгнэлтийг ердийн олонхийн саналаар гаргана.**

Маргаан хянан  
шийдвэрлэх  
ажиллагааны  
**ИХ СУУДАЛ**

Их суудлын хуралдаан хуралдах үндэслэл нь:




Их суудлын хуралдаанаар маргааныг магадлан шийдвэрлэхдээ:







### Маргааныг дахин хянах тохиолдолд хуралдаан нь



### Их суудлын хуралдаанаар албан тушаалтныг хянахдаа:



Маргааныг дахин хянах тохиолдолд хуралдаан нь:



**Хяналтын асуулт:**

1. Цэцийн бага суудлын хуралдааны онцлог юунд орших вэ?
2. Дунд суудлын хуралдаан ямар тохилдолд хуралдах вэ?
3. Магадлалыг аль суудлын хуралдаанаас гаргах вэ?
4. Их суудлын хуралдаанаас ямар шийдвэр гаргах вэ?
5. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг давж заалдаж болох уу?
6. Цэцийн аль шийдвэр эцсийн шийдвэр болох вэ?

**Сорил:**

1. Үндсэн хуулийн цэцийн тогтоолыг хянах эрхтэй этгээд:

- a) УИХ;
- b) Олон улсын шүүх;
- c) хянахгүй;
- d) Ерөнхийлөгч.



**2. Цэцийн гишүүний шийдвэрийн талаар гомдол гаргах эрхгүй этгээд:**

- a) маргагч тал;
- b) Цэцийн гишүүн;
- c) албан тушаалтан;
- d) маргалдагч тал.

**3. Цэцийн дунд суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих арга:**

- a) хянан шийдвэрлэх;
- b) таслан шийдвэрлэх;
- c) магалдан шийдвэрлэх;
- d) эцэслэн шийдвэрлэх.

**4. Цэцийн их суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих арга:**

- a) хянан шийдвэрлэх;
- b) таслан шийдвэрлэх;
- c) магалдан шийдвэрлэх;
- d) урьдчилан шийдвэрлэх.

**Эх сурвалж:**

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2007.

**12. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг татгалзан гаргах үндэслэл, журамтай танилцана.



**Нэр томъёоны тайлбар:**


- **Маргагч тал** Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал идэвхтэй оролцогч тал. Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд **өргөдөл, мэдээлэл, хүсэлт гарган оролцож буй этгээд** нь маргагч тал болно. Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцогч тал. Хэдийгээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд **өөрийн санаачлагаар оролцож буй биш боловч** оролцох үүрэг
- **Маргалдагч тал** хүлээсэн байдаг. Маргалдагч тал нь Үндсэн хууль зөрчсөн тэт маргаан үүсгэсэн хууль, бусад шийдвэрийг гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан байгууллага, албан тушаалтан мөн албан тушаалын байдлаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч байна.

- **Нэгтгэх:** Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад **нэг асуудлаар хоёр буюу хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт байгаа бол тэдгээрийг нэгтгэх замаар асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.**
- **Тусгаарлах:** Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад **нэг өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд хоёр буюу хэд хэдэн өөр шаардлага тавьсан бол тэдгээрийг тусгаарлаж тус бүрд нь шийдвэрлэнэ.**
- **Шинжээч:** Шүүхийн шинжилгээ явуулах зорилгоор шүүхээс татан оролцуулсан **тусгай мэдлэг бүхий этгээд нь шинжээч болно.** Энэ нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд туслах чиг үүрэгтэй бөгөөд шинжлэх ухаан, технологи болон бусад нарийн мэдлэг шаардсан асуудалд мэргэжилтний зүгээс үнэлэлт өгч оролцоно.
- **Мэргэжилтэн:** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч. Шинжээчээс ялгаатай нь судлаач, эрдэмтэн буюу аливаа нэг асуудлаар **мэргэшсэн этгээд байхыг** ойлгоно.
- **Гэрч:** Тухайн хэргийн талаар **тогтоовол зохих нөхцөл байдлыг мэдэж байсан этгээд нь гэрч болно.** Гэрч маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо шүүхэд үнэнийг мэдээлэх үүрэг хүлээсэн байдаг. Гэрч зориуд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэнд тооцно.
- **Хэлмэрч:** Шүүн таслах ажиллагаанд оролцогчийн тайлбар, мэдүүлэг, үйл хөдлөлийг дамжуулах үүрэг хүлээсэн **оролцогч.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үгчлэн явуулах зарчмаас үүдэлтэйгээр оролцогчдын аль нэг өөрийн бодол, саналыг үгээр илэрхийлэх чадваргүй тохиолдолд хэлмэрчээр дамжуулан оролцоно.
- **Орчуулагч:** Шүүн таслах ажиллагаа явагдаж байгаа хэл болон оролцогчийн **хэлийг чөлөөтэй эзэмшсэн шүүх ажиллагааны оролцогч.** Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Монгол хэлээр явуулах зарчмаас үүдэлтэйгээр орчуулагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Өөрөөр хэлбэл, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аль нэг **Монгол хэл мэдэхгүй тохиолдол орчуулагчаар дамжуулан оролцоно.**
- **Татгалзан гаргах:** Хуульд заасан болзол хангасан шүүтчээр хэрэг, маргаанаа хянан шийдвэрлүүлэх зарчмыг хэрэгжүүлэх арга зам. Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнд аль нэг гишүүнийг оролцуулахаас хуульд заасан журмын дагуу татгалзах эрх.




## МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ






*Бусад оролцогчид хамаарах Үндсэн хуулийн шүүхийн онцлог:*




*Маргааныг нэгтгэх ба тусгаарлах нь:*



«Х» хуулийн маргаантай зүйл, заалт хүсэлт, өргөдөл, мэдээлэлд өөр өөр байж болно.



## МАРГААНЫГ ТУСГААРЛАХ НЬ



### МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын эрх:

Хуульд заасан ийтлэг эрх

Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны элцогчид нь тус тусын бүрэн эрхийн хүрээнд адил **тэгш эрх** эдэлнэ.

Гэвч практикийн хувьд маргагч, маргалдагч талуудыг гарааны вдал ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүйн маргааны хувьд **нэг талаас жирийн иргэн, нөгөө талд төр оролцож байдаг.** Иймд тэдний энэхүү байдлыг **тэнцвэржүүлэх үүднээс** нотлох баримтыг **шүүх өөртөө цуглуулдаг.**


### Маргалдагч тал нь дараах эрхтэй:

Цэцэд хянаж байгаа маргааны *материалтай танилцах, холбогдох бичиг баримтыг хуулбарлан авах, тэмдэглэл хийх нотлох баримтыг гаргаж өгөх, нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд оролцох, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бүх асуудлын талаар өөрийн санал дүгнэлтийг гаргах маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд чөлөөтэй мэтгэлцэх, шаардлагатай гэж үзвэл төгсгөлийн үг хэлэх, хүсэлт тавих эрхтэй.*

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын онцгой эрх:


Оролцогч талууд Цэцийн уралдааны бүрэлдэхүүнээс **татгалзан гаргах саналыг** хуульд заасан үндэслэлийн дагуу **тавих эрхтэй.**

*Маргаан хянан шийдвэрлэх ажиллаганаас татгалзан гаргах:*




*Татгалзан гаргахыг шийдвэрлэх:*

Хуралдааны үед гаргасан хүсэлтийн хувьд:





*Татгалзан гарсны үр дагавар:*



Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал хянаж бай асуудлын хүрээнд **Цэцийн хуралдаан зөвлөлдөхөс завсарлахаас өмнө** аль ч шатанд **өөрийн шаардлагын үндэслэл зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах** болон **шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах** эрхтэй.

**Гэвч Үндсэн хуулийн шүүхийн хувьд**

Өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагч шаардлагаас хэдийд ч татгалзах нь **гагцхүү түүнд байдаг эрх**. Хэдий тийм ч Үндсэн хуулийн шүүхи: хувьд хэдийгээр маргагч тал өөрийн шаардлаг татгалзсан байсан ч шийдвэрлэх асуудал нь **нийтийн ашиг сонирхолд** хамааралтай байдаг тул цаа хянан шийдвэрлэдэг. Харин манай Үндсэн хуулда цэцийн хувьд маргагч тал шаардлагаасаа татгалза маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгодог.



## МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ

Оролцогчид мөн өөрсдөө нотлох үүрэг

Маргагч талууд **өөрсдийн шаардлагын үндэслэл** болон **сөрөг шаардлагыг эсэргүүцэж байгаа үндэслэлээ** батлах бичиг баримтыг бүрдүүлж, нөхцөл байдлыг нотлох үүрэгтэй.

Оролцогчид дэгийг сахина

Оролцогч цэцийн хуралдааны дэгийг чанд сахих **хуралдаанд даргалагчид захирагдах үүрэгтэй**. Цэцийн хуралдааны дэгийг дахин зөрчих, цэц болон түүний гишүүдэд хуурамч бичиг баримт өгвөл цэцийг хүндэтгээгүй үйлдэл гэж зохих **хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ**.



## МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бусад оролцогчийн зардлыг

Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон гэрч шинжээч, мэргэжилтэн, орчуулагчийн болон бусад шаардлагатай зардлыг **улсын төсвөөс төлнө**.

**Бусад оролцогч хөдөө оршин суугаа бол зардлыг**

Уг иргэний өргөдөл, мэдээлэл үндэслэлтэй гэж тогтоогдсон бол үндсэн хууль, зөрчсөн хууль, зарилag бусад шийдвэр гаргасан байгууллага албан тушаалтан үндсэн хууль зөрчсөн албан тушаалтан

Өргөдөл мэдээлэл нь үндэсгүй болж тогтоогдсон бол уг иргэн өөрөө хариуцна



### *Хяналтын асуулт:*

1. Хуулийн этгээд үндсэн эрх нь зөрчигдөж байна хэмээн Цэцэд өргөдөл гаргаж болох уу?
2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгч оролцогч болох уу?
3. Сонгуулийн төв байгууллагын ажилтан Цэцэд хүсэлт гаргаж болох уу?
4. Цэцийн хуралдаанд УИХ-ыг хэн төлөөлөх вэ?

### *Сорил:*

#### **№1**

ҮХЦ-ийн дарга Д нь энэхүү ажлаа эрхэлхээс өмнө УИХ-ын гишүүн байсан. УИХ-ын гишүүний сонгуульт хугацаа нь дуусгавар болсоны дараагаар түүнийг ҮХЦ-ийн гишүүнээр томилж, даргаар нь сонгосон.

Д нь УИХ-ын гишүүн байх явцдаа УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилж, уг төслийг УИХ-аас баталсан байна. Гэтэл уг нэмэлтийн тухай хуулийн аль нэг заалт Үндсэн хуулийг зөрчсөн тухай иргэн А Цэцэд мэдээлэл гаргасан байна.

#### **Асуулт:**

1. Д-г Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргаж болох уу. Үндэслэлийг тайлбарла.
2. Д маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарч болох уу? Үндэслэлийг тайлбарла.

#### **№2**

Үндсэн хуулийн цэцэд 2006 онд иргэн А Татварын ерөнхий хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчсөн гэж мэдээлэл гаргасан. Түүнийг нь Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б шалгаж үзээд маргаан үүсгэхээс татгалзах тухай тогтоол гаргажээ. Түүнд нь А гомдол гаргалгүй өнгөрсөн байна.

Гэтэл 2009 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр иргэн Г нь мөн Татварын ерөнхий хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 16 дахь хэсгийг зөрчсөн хэмээн үзэж Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ.

#### **Асуулт:**

1. Үндсэн хуулийн цэц Г-ийн мэдээллээр маргаан үүсгэн шалгаж болох уу?
2. Хэрэв Г-ийн мэдээллээр маргаан үүсгэж шалгах бол А-ийн мэдээллээр маргаан үүсгэхээс татгалзсан гишүүний тогтоолтой зөрчилдөх үү?

## *Эх сурвалж:*

1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005.183- 199 дэх тал.
2. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999,114 дэх тал.
3. Монголын төр эрх зүй. Сэтгүүл, УБ., 2004, №4, 7-12 дах тал.
4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль. 1997

## **13. Маргааныг цэцийн хуралдаанаар хянан шийдвэрлэх**

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн хуралдаан, маргаан хянан шийдвэрлэх журам, шийдвэр гаргах үйл явцтай танилцана.

## *Нэр томъёоны тайлбар:*

### **• Цэцийн хуралдаан**

Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх **маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа.**

### **• Зөвлөлдөх**

Цэцийн хуралдаан зөвлөлдөх тасалгаанд шилжиж шийдвэр гаргах үйл явц. Цэц зөвлөлдөх тасалгаанд асуудал шийдвэрлэхэд Цэцийн хуралдаанд оролцсон гишүүн бүр адил тэгш эрхтэй бөгөөд шийдэх гэж байгаа асуудлын талаар өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, саналаа хэлэх эрхтэй.

### **• Шийдвэр сонсгох**

Маргааныг хэрхэн шийдвэрлэсэн болохыг мэдэгдэж буй үйл ажиллагаа. Цэц зөвлөлдөх тасалгаанд шийдвэрээ гаргасны дараа хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнд орсон бусад гишүүд гарын үсэг зурж, хуралдаан даргалагч буюу түүний даалгаснаар аль нэг гишүүн нийтэд уншиж сонгодог.


### **• Асуулт**

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад асуудлыг тодруулах зорилгоор хариулж буй хэлбэр. Цэцийн бүрэлдэхүүнд орсон гишүүд хуралдааны аль ч шатанд хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр оролцогчдод асуулт тавьж, хариулт авах эрхтэй.



### 13.1. Хуралдааны үе шат


#### Хуралдааны өмнө






ХУРАЛДААНЫ ДАРААЛАЛ

Хуралдаан даргалагч хэлэлцэх асуудлыг танилцуулна.





### 13.2. Хуралдааны шийдвэр гаргах ба нууц зөвлөлдөх



#### ЦЭЦ НУУЦ ЗӨВЛӨЛДӨХ

#### НУУЦ ЗӨВЛӨЛДӨХ НЬ

**Зөвлөлдөх тасалгаанд**

Энэхүү зарчмыг баримтлана


Зөвлөлдөх тасалгаанд асуудал шийдвэрлэхэд Цэцийн хуралдаанд оролцсон **гишүүн бүр адил тэгш эрхтэй** бөгөөд тухайн **шийдэх гэж байгаа асуудлын талаар өөрийн санал**, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, тайлбарлах эрхтэй.

**Зөвлөлдөх тасалгаанд санал гаргахдаа**


- Маргааныг хуралдаанд илтгэсэн гишүүн өөрийн санал, дүгнэлтийг эхэлж гаргах
- Түүний дараа хуралдаанд оролцсон гишүүдийн хамгийн ахмад настай гишүүнээс эхлэн насны эрэмбээр дүгнэлт, саналаа хэлж, хуралдаан даргалагч эцэст нь саналаа гаргана

Цэцийн хуралдаанд оролцсон гишүүн зөвлөлдөх тасалгаанд асуудал шийдвэрлэхэд саналаа заавал өгнө.

Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн **санал тэнцсэн, маргааны талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай болсон** бол Цэц уг маргааныг 30 хоногийн дотор дахин хянан хэлэлцэж шийдвэрлэхээр хойшлуулж, энэ тухай магадлал гаргана.



## ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙГ СОНСОХ



### Хяналтын асуулт:

1. Цэцэд аман хуралдаан хийлгүйгээр хуралдааныг дан зөвлөлдөх тасалгааны хэлбэрээр явуулж болох уу?
2. Шүүхийн зөвлөлдөх тасалгаанд хуралдааны нарийн бичгийн дарга орох журам түгээмэл эсэх.
3. Цэцийн хуралдаан ямар үе шаттай вэ, ердийн шүүхээс ялгагдах онцлог байна уу?
4. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гэрч зориуд худал мэдүүлэг өгчээ, энэ тохиолдолд яах вэ?

### Сорил:

#### 1. Цэцийн шийдвэрийг бичих гишүүн

- a) илтгэгч гишүүн;
- b) хуралдаан даргалагч;
- c) хэн нэг гишүүн;
- d) нарийн бичгийн дарга.

#### 2. Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хуралдаан даргалагч илүү эрх эдлэх үү?

- a) зохион байгуулалтын хувьд;
- b) асуудлыг шийдвэрлэхэд;



- c) гишүүдийн санал тэнцэхэд;
- d) эрх эдлэхгүй.

### 3. Цэцийн шийдвэрийн агуулгыг:

- a) «Төрийн мэдээлэл» сэтгүүлд нийтэлнэ;
- b) Цэцийн шийдвэрийн эмхтгэлд нийтэлнэ;
- c) «Шүүх эрх мэдэл» сэтгүүлд нийтэлнэ;
- d) Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

### 4. Шүүх хуралдааныг хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэхэд Цэцээс гардаг баримт бичиг:

- a) бичгээр магадлал гаргана;
- b) тогтоол гаргана;
- c) амаар магадлал гаргана;
- d) дүгнэлт гаргана.

#### *Эх сурвалж:*



1. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ.> 2005. 211-218 дах тал
2. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999, 114 дэх тал
3. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг. УБ0 2009, 354 дэх тал
4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль. 1997

## 14. Маргааныг магадлан шийдвэрлэх

**Сэдвийн зорилго:** Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар маргааныг магадлан шийдвэрлэх үндэслэл, журамтай танилцана.


#### *Нэр томъёоны тайлбар:*

- **Магадлан шийдвэрлэх** Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хэлбэр. Маргааныг эцэслэн шийдвэрлэж буй үйл ажиллагаа бөгөөд их суудлын хуралдаанаар шийдвэрлэдэг. Маргааныг магадлан шийдвэрлэсэн их суудлын хуралдааны тогтоол гармагц хүчин төгөлдөр болно.





### Маргааныг магадлан шийдвэрлээд гаргах шийдвэр:



### Хяналтын асуулт:

1. Ямар тохиолдолд маргааныг цэцийн хуралдаанаар магадлан шийдвэрлэх вэ?
2. Маргааныг магадлан шийдвэрлэх журам ба цэцийн шийдвэрийг давж заалдах үндэслэлийг тайлбарлана уу?
3. Маргааныг магадлан шийдвэрлэх цэцийн бүрэлдэхүүн ямар байх вэ?

### Сорил:

#### 1. Ямар тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт эцсийнх болох вэ?

- а) Дүгнэлт гармагц
- б) УИХ хүлээж авснаар
- в) Дүгнэлт гарснаас хойш 15 хоногийн дараа
- д) Магадлан шийдвэрлэж тогтоол гарсан бол

#### 2. Их суудлын хуралдаанд бэлтгэж буй гишүүн (үл хамаарахыг ол).

- а) Урьд маргаан шалгасан гишүүн
- б) Томилогдсон гишүүн
- в) Цэцийн дарга
- д) Бүгд зөв

#### 3. Их суудлын хуралдааны тогтоолд гомдол гаргаж болох уу?

- а) Бүх шийдвэрт болно
- б) Бүх шийдвэрт гомдол гаргаж болохгүй
- в) Зөв хариулт алга байна

### Эх сурвалж:

1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын тайлбар, УБ., 1999.
2. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй. Суурь ойлголт, тулгамдсан асуудал, УБ., 2005.
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2007.

## 15. Цэцээс хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох хязгаар

**Сэдвийн зорилго:** Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэцийн хоорондын харилцааны улс төр - эрх зүйн үндэс, цэцийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлын асуудалтай танилцана.

**Нэр томъёоны тайлбар:**

- Erga omnes Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг бүх нийтээр дагаж мөрдөх тухай ойлголт.
- Interpartes Үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр зөвхөн маргалдагч талуудад хамааралтай байх тухай ойлголт.
- Үндсэн хуулийг дээдлэх зарчим Үндсэн хуулийг төрийн дээд байгууллага, албан тушаалтан дээдлэн хүндэтгэх үндсэн хуулыг ёсны зарчим.

**Үндсэн хуулийг хэн тогтоох вэ?**



**Хэн хууль тогтоох вэ?**



Үндсэн хуулыг ардчилсан төрийн тогтолцоотой улсад Үндсэн хуулийг тогтоогч нь зөвхөн ард түмэн байдаг. Энэ нь тухайн улсын Үндсэн хуулийн оршилд тусгалаа олсон байдаг.

Үндсэн хуулыг ардчилсан төрийн тогтолцоотой улсад хуулийг гагцхүү ард түмний төлөөллөөс бүрдсэн парламент тогтоодог. Харин парламентын баталсан хууль Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэх зарчимтай холбоотой.






## ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ ХУУЛЬ ТОГТООХ УУ?

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн байгууллагын хувьд хууль тогтоох байгууллагатай нэг шатанд байх бөгөөд түүний үйлдэл Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж байдаг ч өөрөө хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэггүй.

Сонгодог утгаараа Үндсэн хуулийн шүүх нь шийдвэр гаргахдаа хууль тогтоогч нь Үндсэн хуулийг баримталж байгааг хянахаас бус, улс төрийн шийдвэр гаргахаас татгалздаг. Тийм ч учраас орчин үеийн үндсэн хуульд төрийн зорилгыг **улс төрийн эрх мэдлийг эрх зүйн арга хэрэгслээр хязгаарлах явдал** мөн гэж тодорхойлох нь түгээмэл болсон. Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн шүүх өөрийн шийдвэрийнхээ үндэслэлээр Үндсэн хуулийг тайлбарлаж, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлж байдаг.

### *ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР БҮХ НИЙТЭЭР ДАГАЖ МӨРДӨХ ШИНЖТЭЙ БОЛОХ НЬ:*

Европын загвар бүхий улсуудад Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь бүх нийтээр дагаж мөрдөх шинжтэй байдаг. Энэ нь үндсэн хуулийн бүхий л байгууллага, бусад шүүх, захиргааны байгууллага, албан тушаалтанд хамаарна.



Ардчилсан эрх зүйт төрийн тогтолцоонд хууль тогтоогч болон үндсэн хуулийн шүүхийн хоорондын харилцаанд үргэлж зөрчил үүсэж байдаг. Гэвч үүнийг тэвчих л хэрэгтэй. Үндсэн хуулийн байгууллагууд бие биенээ хүндэтгэх нь ардчилсан эрх зүйт төрийн хувьд хамгийн чухалд тооцогддог.

### *Хяналтын асуулт:*

1. Erga omnes гэж юу вэ?
2. Interpartes гэх ойлголтын хууль зүйн агуулгыг тайлбарла.
3. Үндсэн хуулийн цэц ба УИХ-ын хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн асуудалд юуг хамруулвал зохих вэ?
4. Үндсэн хуулийг тогтоогч, хууль тогтоогчийн ялгааг тайлбарла.
5. Үндсэн хуулийг дээдлэх зарчим, ардчилсан ёсны зарчмын талаар ярилцана уу.

### *Эх сурвалж:*

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ. 2007.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт: төлөв байдал, цаашдын хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал (илтгэлийн эмхтгэл). УБ.,2008